Мега төслүүдийг ирэх хавраас хөдөлгөнө
Эдийн засгийн бодит өсөлтийг 2017 онд гурав, 2018 онд 5.1 хувьд хүргэхээр тусгажээ. > 2

Агуу Петрагийн эх нутаг Йордан
Петрагийн эх түүхийг ойлгохын тулд бараг хоёр өдөр энд өнжих хэрэг гарна. > 7

Төв банк уян хатан ханшаар валютын нөөцөө хамгаалдаг
Банк ороод нэг сая ам.доллар авъя гэвэл “Манайх зарахгүй” гэх тохиолдол гарсан. > 11, 12

FT FINANCIAL TIMES
■ ХБНГУ цөмийн хаягдлын зардлаа шийдвэрлэв
■ Лондоны “боссууд” ажилчдыг удирдах зөвлөлд оруулна

NNC NATIONAL NEWS CORP | БҮРЭЛДЭХҮҮН КОМПАНИ

ZASAG.CO

МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2016.10.21, БААСАН ~ №222 (500)

ҮНЭ: 600₮

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Ерөнхийлөгч Монгол Улсын 2017 оны төсвийн төсөлд санал хүргүүлэв.

УИХ-ын дарга Хятадаас хөгжлийн зээл авах сонирхлоо илэрхийлжээ.

19 аймгийн 117 нэр дэвшигчийн санал тэнцсэн тул дахин сонгууль явуулна.

Ам.долларын ханшийг ирэх онд 2250 төгрөг байхаар тооцжээ.

ГХЯ-ны ТНБД Д.Даваасүрэн Хойд Америк-Монголын бизнесийн зөвлөлийнхөнтэй уулзав.

ЭДИЙН ЗАСАГ

Борлуулалтын менежерүүдийн индекс энэ сард буурч, 39.5 нэгж болов.

“Оюутолгой”-н хүдрийн олборлолт өмнөх улиралд 25.7 сая тоннд хүрч, өслөө.

ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2.5 тэрбум төгрөг болгов.

БНХАУ-ын эдийн засаг гуравдугаар улиралд 6.7 хувиар тэллээ.

ОХУ-ын дундаж цалин өнгөрсөн сард 2.8 хувиар өссөн байна.

НИЙГЭМ

Германы буцалтгүй тусламжаар "Вольф" бенз загварын автомашинуудыг БХЯ-нд өгөв.

Нийслэлд он гарсаар долоон хүүхэд түлэгдэж, дөрвөн хүүхэд галд амиа алджээ.

Худалдаа эрхлэгчид хүнсний бүтээгдэхүүнийг 15-52 граммаар дутуу савладаг аж.

10 гаруй хүнийг гэмтээж, дээрэмдсэн этгээдүүдийн гурвыг нь баривчилжээ.

Хууль, эрх зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх өдөрлөг энэ сарын 28-нд болно.

ДЭЛХИЙ

Филиппиний Ерөнхийлөгч АНУ-ын талаар дахиад таагүй мэдэгдэл хийв.

Путин, Меркель, Олланд нар Сирийн асуудлыг хэлэлцлээ.

Хиллари Клинтон ОХУ-ыг хакерын халдлагад буруутгав.

Шотланд тусгаар тогтнох асуудлаар дахин санал хураахаар төлөвлөж байна.

Mitsubishi Motors-ийн удирдлагыг Nissan-ы Ерөнхийлөгчөд шилжүүлнэ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2016.10.21

3° | -6°

ҮҮЛШИНЭ

ЦАГ АГААРЫН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ 8 ДУГААР НҮҮРЭЭС УНШИНА УУ.

8 658000 029112 00500

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Нөөцийн махгүй хавар

Үйлдвэрүүд уг нь өдийд бэлтгэлээ базаах учиртай. Гэвч нөөцийн махны сураг алга. ▶11

Б.Ганбаяр / ЗГМ©

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Буруу хэвшлийн төлөөс

Р.Оюунцэцэг
@oyuntsetsegZGM

Хийжүүлсэн ундаа эрүүл мэндэд хортой гэдгийг мэдэхгүй хүн байхгүй хэрнээ бүгд л хэрэглэдэг. Яг ямар хортой гэж. Үнэндээ нарийн учрыг мэдэхгүй болохоор татгалзаж чадахгүй уусаар. Харин уух дур хүслийг өдөөж, арааны шүлс асгаруулдаг тэрхүү ундаа таны амаар ороод бие организмд ямар хэрэг тарьдгийг мэдчихвэл “болохгүй” гэдэг дохио тархинд тань бат суука гэдэгт итгэлтэй байна. Таны биед ямар үйл явц болдог талаар шинжлэх ухаанаар тогтоосон тайлбарыг харъя.

Хийжүүлсэн ундаа уухад таны ходоодонд тодорхой хэмжээний хий орж, ходоод аяндаа тэлдэг. Яг л агаарын бөмбөлөг үлээж байгаа мэт. Энэ үед ходоодонд хоол орж ирлээ гэсэн дохиог тархинд өгнө. Бидний бие организм маш ухаалаг бөгөөд нарийн зохион байгуулалттай цогц систем. Үйлдвэр л гэсэн үг. Ийм дохио авсан ходоод орж ирсэн хоолыг боловсруулахын тулд хүчил ялгаруулна. Харамсалтай нь, ходоод хуурtсан.

▶3

FT

Хятадад орон сууцны үнэ хадаж байна

Юань Ян, Том Митчелл

Хөбэй мужийн Гу-Ань хошууны орон нутгийн захиргааны үүдэн дэх урт дараалалд зогссоор Пэн Гуаншэн тавдугаар сарыг өнгөрөөжээ.

Дорнод Хятадын Сужоу мужаас ирсэн, “Вайди Рен” буюу гадны хүнд тооцогдох тэрбээр Гу-Ань хошуунд үл хөдлөх хөрөнгө худалдан авахын тулд тусгай зөвшөөрөл авах ёстой. Бээжин хотын захад ойр орших уг хошуунд гадны хүнд худалдах үл хөдлөх хөрөнгийн тоог ганцаар хязгаарладаг.

Урт дараалалд зогссоны хэрэг ч гарсан. Худалдаж авсан үл хөдлөх хөрөнгөө Пэн овогт хэдэн сарын дараа эргүүлээд үлэмж ашигтай зарж орхижээ.

▶9

ЗГМ: ИНФОГРАФИК



MSE ALL	АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	5-ЧИНГИС БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
819.37 0.38%	1269.40 0.04%	4671 0.21%	89.830 0.1%	96.700 0.02%	2319.29	344.15	36.86

Улс төр

СОНГОЛТ-2016

19 аймагт дахин санал хураана

Нийслэлийн 152 хорооны 73 дээр нь сонгогчдын 50-иас дээш хувь нь саналаа өгсөн

Б.Даваатогтох
@datoZGM

Б.Ганбаяр / ЗГМ©

Монгол Улс ардчилалд шилжсэн 26 жилийн хугацаанд сонгуулийн ирц тогтмол уруудаж байсан. Гэвч өнгөрсөн зургадугаар сард болсон УИХ болон аймаг, нийслэлийн сонгуулиар ирц нэмэгдэж, 72.1 хувьд хүрсэн. Тэгвэл өнгөрсөн лхагва гарагт болсон сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд сонгогчдын идэвх буурч, нийслэлийн зарим хэсгийн хороодод нэмэлт санал хураалт болохоор хүрэв. Тухайлбал, нийслэлийн 152 хорооны 73 дээр нь сонгогчдын 50-иас дээш хувь нь саналаа өгсөн бол 79 хороо ирц хүрээгүй байна. Тодруулбал, нийслэлийн хэмжээнд нийт 860 мянга 452 иргэн сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгүүлснээс 48 хувь нь буюу 413 мянга 212 сонгогч саналаа өгсөн байна. Ингэснээр ирц хүрээгүй хороодод ирэх ням гарагт нэмэлт санал хураалт явуулахаар болов. Гэхдээ саналаа өгсөн иргэд дахин өгөхгүй. Харин саналаа өгч амжаагүй иргэд сонголтоо хийж, саналын дүнг өмнөх ирцэн дээр нэмж тооцуулах юм.

Харин 21 аймгийн хувьд сонгуулийн ирц харьцангуй өндөр. Гэхдээ 57 тойрогт сонгуулийн ирц хүрээгүй учир нэмэлт сонгууль явуулахаар болсныг Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн өнгөрсөн пүрэв гарагт онцолсон. Тодруулбал, нэг аймагт 1-3 тойрогт нэмэлт сонгууль явуулахаар байгаа аж. Энэ талаар СЕХ-ны дарга Ч.Содномцэрэн “Сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд 1765 тойрогт 15111 нэр дэвшигч өрсөлдсөн тул мэдээллийг шуурхай нэгтгэх боломжгүй байлаа. Сонгуулийн дүнг долоо хоногийн дараа нийтэд мэдээлэхээр хуульд заасан байдаг. Зарим хороонд ирц хүрээгүй учраас ирэх ням гарагт дахин санал хураана. Нийт 1765 тойргийн 135 дээр нэмэлт санал хураалт явуулна. Мөн энэ удаагийн орон нутгийн сонгуулиар нэр дэвшигчийн санал тэнцсэн тохиолдол гарсан. Хуулиараа шийдвэр гарснаас хойш долоо хоногийн дотор дахин санал хураалт явуулах заалттай. Иймээс 19 аймгийн 117 нэр дэвшигчийн санал тэнцсэн тул шинээр саналын хуудас хэвлэж, энэ сарын 29-нд дахин санал хураалт явуулна. Дахин санал хураалт явуулахад тухайн хэсгийн бүх сонгогч очиж саналаа өгнө. Тодруулбал, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв болон Увс аймгийн зарим тойрогт дахин санал хураалт явуулахаар болов. Харин нийслэлд саналаараа тэнцсэн нэр дэвшигч байхгүй тул дахин санал хураалт явуулахгүй. Дахин сонгууль явуулах хүртэл шилжилт хөдөлгөөн явуулахгүй” гэлээ.

» Нийт 1765 тойргийн 135 дээр нэмэлт санал хураалт явуулна.

» 19 аймгийн 117 нэр дэвшигчийн санал тэнцсэн тул шинээр саналын хуудас хэвлэж, энэ сарын 29-нд дахин санал хураалт явуулна.

» Сүхбаатар, Сэлэнгэ, Төв болон Увс аймгийн зарим тойрогт дахин санал хураалт явуулахаар болов.

» Анх удаагаа сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийг дангаар явуулсан нь сонгогчдын ирц буурахад нөлөөлсөн.

Тэгвэл энэ удаагийн орон нутгийн сонгуулиар сонгогчдын ирц буурсанд судлаачид олон янзын дүгнэлт хийжээ. Тухайлбал, анх удаа сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийг дангаар явуулсан нь сонгогчдын ирц буурахад нөлөөлсөн гэж үзжээ. Өөрөөр хэлбэл, орон нутгийн сонгуулиас аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуулийг “сугалан” авч УИХ-ын сонгуультай хамтатгасан нь сонгогчдын оролцоо сулрахад голлох нөлөө үзүүлсэн гэсэн таамаг дэвшүүлэв.

Мөн сонгогчийн боловсролын түвшин доогуур байгаа нь сонгуулийн ирцэд нөлөөлж байна хэмээн дүгнэжээ. Монгол Улс ардчилсан тогтолцоонд шилжсэн цагаас хойш өнөөг хүртэл Монгол Улсын Засгийн газар иргэний болон сонгогчийн боловсролыг дээшлүүлэх талаар нийтийг хамарсан ажил зохион байгуулж байгаагүй. Энэ нь сонгуулийн ирцэд сөргөөр нөлөөлсөн. Сонгогчдын хувьд өөрт байгаа төрийн эрх барих боломжийг ашиглалгүй хайнга хандаж байгаа нь сонгогчийн боловсролтой шууд холбоотой гэж үзэж байгаа аж.

Үүнээс гадна төр засаг болон улс төрийн хүчнүүдийн нэр хүнд тааруу байгаа нь иргэдийн сонгуульд оролцож саналаа өгөх идэвхийг бууруулахад нөлөөлсөн хэмээн үзжээ. Сүүлийн жилүүдийн эмпирик судалгааны дүнгээс төрийн байгууллага, албан тушаалтан, улс төрийн намуудад итгэх иргэдийн итгэл сул, түүнд өгөх үнэлгээ муу байгаа нь илт бий. Сонгууль шударга болж чадахгүй гэсэн сонгогчийн бодол нь сонгуулийн ирцэд сөргөөр нөлөөлдөг гэсэн таамаглал ч дэвшүүлсэн байна.

Ямартай ч, энэ удаагийн орон нутгийн сонгуулийн үр дүнд нэмэлт болон дахин санал хураалт явуулахаар болов. Орон нутгийн сонгуулийг зохион байгуулахад төрийн 20 орчим мянган албан хаагч оролцож, 13.9 тэрбум төгрөг зарцуулсан юм. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» ЕРӨНХИЙЛӨГЧ
Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж УИХ-аар 2017 оны төсвийн төслийг хэлэлцэн батлахтай холбогдуулан УИХ-ын дарга М.Энхболдод санал хүргүүлэв. Тэрбээр Хүүхэд харах үйлчилгээний төсвийн санхүүжилтийг ирэх оноос эхлүүлэх, орон нутгийн хөгжлийн санд олгох улсын төсвийн түвшинг бууруулахгүй байх, өндөр насны тэтгэвэрт гарч буй багш, эмч, цэргийн алба хаагчдын нэг удаагийн тэтгэмж 36 сар байх зэрэг санал хүргүүлжээ.

» МЭДЭЭЛЭЛ
УИХ-ын даргын БНХАУ-д хийсэн зургаан өдрийн айлчлал өндөр үр дүнтэй болсныг Г.Занданшатар гишүүн онцлоод, ОУВС, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллага, хөгжлийн банкууд, хөрш орнууд болон хандивлагч орнуудаас зээл тусламж хүссэн гэв. Тухайлбал, Хятад улсаас жилийн хүү нь хоёр хувиас ихгүй, хугацаа нь 20 жилээс дээш байх хөгжлийн зээл авах сонирхлоо илэрхийлсэн байна.

» УУЛЗАЛТ
Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн Хойд Америк-Монголын бизнесийн зөвлөлийн тэргүүн Франк Херберт болон тус зөвлөлийн ерөнхийлөгч Стив Сандерс тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. Уулзалтын үеэр Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн гадаадын хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулагчдын итгэлийг дахин сэргээх чиглэлд Монгол Улсын Засгийн газрын авч хэрэгжүүлж буй арга хэмжээг танилцуулав.

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжлагатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

› OPED@ZASAG.CO

Утас: 99901526 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

БАЙНГЫН ХОРОО

Мега төслүүдийг ирэх хавраас хөдөлгөнө

Б.Тогтох
ЗГМ

Б.Ганбаяр / ЗГМ©

УИХ-ын Төсвийн байнгын хорооны хуралдаанаар 2017 оны төсвийн хүрээний мэдэгдлийн хэлэлцлээ. Төсвийн хүрээний мэдэгдэлд уул уурхайн томоохон төслүүдийг эрчимжүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдыг татахыг чухалчлав. Ингэж эдийн засгийг солонгоруулах замаар ДНБ-д эзлэх эдийн засгийн бодит өсөлтийг 2017 онд гурав, 2018 онд 5.1, 2019 онд 7.1 хувьд хүргэхээр тусгажээ. Тодруулбал, “Оюутолгой” төслийн далд уурхай, “Тавантолгой”, “Тавантолгой цахилгаан станц”, “ДЦС-3”-ын өргөтгөл, “Гацуурт” зэрэг томоохон төслийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх замаар төсвийн орлогыг нэмэгдүүлнэ хэмээн тооцжээ. Мөн Засгийн газраас өмч хувьчлалын бодлого боловсруулж, төрийн өмчит хуулийн этгээдийг хувьчлах, алдагдалтай ажиллаж байгаа төрийн өмчит компанийн менежментийг сайжруулахаар тусгасан байна.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан УИХ-ын гишүүд санал хэлж, байр сууриа илэрхийлсэн юм. Тухайлбал, УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэн “Эдийн засгийн өсөлтийг 2019 онд 7.1 хувь гэж тооцсон байна. Тэгсэн хэрнээ хөдөө аж ахуйн салбарын өсөлт буурсан дүнтэй байна. Яагаад ингэж буурч байгаа юм бэ. Эдийн засаг хөдөө аж ахуйн салбараас үл хамаарч өсөх юм уу. Ирэх онд өрийн хэмжээ хэд болох вэ” хэмээн тодруулав.

Сангийн сайд Б.Чойжилсүрэн “Өрийн хэмжээг ДНБ-ий 84.8 хувиас хэтрүүлэхгүй байхаар тооцсон. Уул уурхай, эрчим хүчний салбарын өсөлт эдийн засагт гол нөлөө үзүүлнэ гэж тооцоод байна. Энэ салбарын томоохон төслүүдийн бэлтгэл ажлыг хангаж, ирэх хавар бүтээн байгуулалтын улирал эхлэхээр ажлыг нь эхлүүлнэ. “Оюутолгой” төслийн үйл ажиллагаанд дүгнэлт хийх Ажлын хэсэг ажиллаж байгаа. Энэ сарын 25-нд дүгнэлт нь гарна. Томоохон төслүүдийг Монголд ашигтай ажиллуулна. Гацууртын ордыг ашиглуулах, эсэхийг Канадын Засгийн газар манайхаас асууж байгаа. Засгийн газар энэ ордыг ашиглах нь зүйтэй гэж үзсэн” гэлээ.

Харин Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын дарга Г.Батхүрэл “Хөдөө аж ахуйн салбарын өсөлт 2017 онд 9.1, 2018 онд 8.3, 2019 онд 7.8 хувьтай байна гэж үзсэн. Хөдөө аж ахуйн салбарын 10 хувийг л газар тариалан эзэлдэг. Энэ оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 61 сая толгой мал тоологдоно гэж үзэж байгаа. 2018 онд 68, 2019 онд 70 сая малтай болно гэж тооцсон. Өнгөрсөн жилүүдэд хөдөө аж ахуйн салбар сууриараа өссөн. Төсөвт өсөлтийг нь тооцохдоо сууриас нь тооцож буй учраас ийм бага харагдаж байгаа юм” хэмээн нэмэлт тайлбар өгөв.

УИХ-ын гишүүн Ж.Батзандан “Томоохон төслүүдээс орлого олно гэж өмнөх Засгийн газрууд олон жил ярьсан. Гэвч олигтой орлого олж байгаагүй. Харин Оюутолгойгоос орлого олох бус өрөнд орсон. Энэ Засгийн газар ч том төслүүдээ хөдөлгөнө л гэж байна. Хамгийн гол нь Монголд ашигтай хөдөлгөх хэрэгтэй” хэмээн байр сууриа илэрхийллээ.

Мөн ОУВС-гийн “Standby” хөтөлбөрт хамрагдах, эсэх болон БНХАУ-аас их хэмжээний зээл авах, эсэхийг УИХ-ын гишүүд тодруулав. Сангийн сайд Б.Чойжилсүрэн “ОУВС-гийн техникийн баг нь энэ сарын 24-нөөс арваннэгдүгээр сарын 4 хүртэл ажиллана. БНХАУ-аас 20 жилийн хугацаатай, хоёр хувийн хүүтэй зээл авах хүсэлт гаргасан. Энэ асуудлаар хоёр талаасаа Ажлын хэсэг гаргаж ажиллана” гэв.

Ирэх онд ам.долларын ханшийг 2250 төгрөг байхаар тооцсон

УИХ-ын гишүүн Х.Баделхан үйлдвэрлэлийн салбарын өсөлтийг хэрхэн 17 хувиар нэмэгдүүлэх гэж байгааг лавлав. Сангийн сайд Б.Чойжилсүрэн “Энэ тооцоолол бодитой. Тухайлбал, сая УИХ-ын даргын айлчлалын үеэр зэс хайлуулах үйлдвэр байгуулах асуудлаар яриа хэлэлцээ хийсэн” гэлээ.

Харин Төсвийн байнгын хорооны дарга Ч.Хүрэлбаатар “УИХ энэ оны төсвийн тодотголыг есдүгээр сарын 9-нд баталсан. Засгийн газар 21-хэн хоногийн дараа ирэх оны төсвийн төслийг оруулж ирэхдээ өмнөх тоонуудаа өөрчилсөн байна. Тухайлбал, 2017 онд эдийн засгийн өсөлт 2.3 хувьтай байна гэж тооцсоныг гурав, 2018 онд 3.4 хувь гэж тооцсоныг 5.1 болгод өсгөчихсөн. Олон улсын байгууллагууд манай улсын эдийн засгийг төсвийн тодотгол батлах үед тооцсоноос бага байна гэсэн таамаглал дэвшүүлсэн. Ам.долларын ханш 2300 давчихлаа. 2017 онд ам.долларын ханшийг хэдээр тооцсон бэ. Монголбанк мөнгөний бодлогын баримт бичигтээ “ОУВС-гийн “Standby” хөтөлбөрт хамрагдмаар байна” гээд биччихсэн байна. Засгийн газар ямар байр суурьтай байгаа юм бэ” хэмээн асуув.

Сангийн сайд Б.Чойжилсүрэн “Төсвийн тодотголыг батлах үед УИХ-ын гишүүд нөөц боломжоо бүрэн дайчлахгүй байна гэсэн шүүмжлэл хэлж байсан. Тиймээс бид хэтэрхий болгоомжлоод байгаа юм биш биз гэж үзээд зарим тооцоолуудаа өөрчилсөн. Нэгэнт өөдрөгөөр төсөөлсөн юм. Ирэх онд ам.долларын ханшийг 2250, 2018 онд 2310 төгрөг байхаар тооцсон. Эдийн засгийн хүндрэлийг давах онцгой хөтөлбөр ирэх оны төсөвтэй хамт хэрэгжих байх. Харин ОУВС-гийн “Standby” хөтөлбөрт хамрагдах, эсэхээ эцэслэн шийдээгүй байгаа” гэлээ.

Ингээд хуулийн төслийг хэлэлцэх, эсэх талаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүд 100 хувь дэмжив. [ЗГМ]

Нийтлэлчийн булан

С.Батсайхан / ЗГМ©

Ам руугаа хийж буй бүхнээ ухамсартайгаар сонгож, илчлэгийг тооцдог болохоос л өөр аргагүй гэдгийг хоол тэжээлийн хөгжил харуулж байна.

Буруу хэвшлийн төлөөс

Эрүүл хоол байсан ч хэт хурдан идсэн л бол тэр чигтээ хор

◀1

Хоол биш, хий байсан тул ялгарсан тэр хүчил эргээд ходоодны ханаа идэж эхэлдэг. Энэ үйл явц нь өлсөх мэдрэмжийг ихээр төрүүлдэг байна. Угаасаа ходоодны асуудалтай хүмүүсийнх бүр ч илүү гэмтэнэ гэсэн үг.

Үүнээс гадна хийжүүлсэн ундаа ихээр хэрэглэхэд орж ирсэн хийг гаргах буюу хэхрүүлэх өвчтэй болдог. Хүний ходоод, хоол боловсруулах систем доошоо урсгалтай. Орсон хоол хүнсийг боловсруулаад доош нь явуулж, гадагшлуулна. Харин хэхрүүлэх нь тэр урсгалыг байнга сөрж байгаа хэрэг. Угтаа эрүүл бус тогтолцоо үүсгэж буй нь энэ. Түүнчлэн хийжүүлсэн ундаанд их хэмжээний сахар агуулагддаг тул биед тань илчлэг ихээр орно. Ялангуяа сахар орлуулагч ашигладаг “Light” тодотголтой ундаанууд ердийнхөөсөө ч долоон дор ажээ.

Дээр нь мэдээж ясны сийрэгжилтэд нөлөөлнө. Биеэ зовоон байж олсон мөнгөөрөө өөрийгөө ингэж гэмтээх хэрэг байна уу гэж эрхгүй бодогдохоор байгаа биз. Энэ тайлбарыг “Хербалайф” компанийн Хүнс тэжээлийн мэргэжилтнүүдийн шинжлэх ухааны зөвлөлийн гишүүн, дэд доктор, хоолзүйч, дотрын эмч Александр Мартынчук ням гарагт Монгол Улсад саатахдаа хэлсэн юм. Тэрбээр ходоод, нарийн гэдэсний эмгэг судлал, таргалалтын эмчилгээний чиглэлээр Женев, Парис, Будапешт, Истанбул зэрэг томоохон хотуудад зохион байгуулсан олон улсын бага хурлуудад илтгэл хэлэлцүүлж, орчин үеийн хоол зүй, ходоод, нарийн гэдэсний эмгэг судлал, эмчилгээний чиглэлээр эрдэм шинжилгээний 33 бүтээл туурвисан, энэ чиглэлээр мэргэшсэн нэгэн. Түүний ярианаас эшлэх олон санаа бидний хоолны талаарх буруу ойлголтыг засахад дэм болохоор байв.

Бас нэг буруу ойлголт. Өөх тостой хүнс л бол таргалуулдаг гэдэг ойлголтын зөрүүнээс болоод зарим эрдэс, шим тэжээлээ авч чаддаггүй өнгөрөөдөг ажээ. Тухайлбал, амьтны болон ургамлын гаралтай өөх тосыг хүн аль алийг нь тодорхой хэмжээнд авч байх ёстой. Амьтны гаралтай өөх тос нь тархины эд эсийн хөгжилд шаардлагатайгаас гадна гармоны зөв зохистой үйл ажиллагаанд хэрэгтэй ажээ.

Эмэгтэйчүүд дэлгүүрийн лангуун дээрээс тараг сүү авахдаа “Тослог 0%” гэснийг нь сонгох болсон. Энэ бол буруу сонголт аж. Хүн сүү, тараг, цагаан идээнээс ураг, бас кальци авдаг. Мэдээж кальци бол ясны эрүүл мэндэд хамгийн хэрэгтэй элемент. Яс, хумс сайхан байх нь ч кальцийн хэмжээтэй холбоотой. Тэр ч байтугай кальци нь эрчимтэй жин хаяхад чухал үүрэгтэй болохыг эрдэмтэд судалж, тогтоожээ. Харин энэхүү элементийг биедээ, ясандаа тэжээл болгон үлдээхийн тулд Д витамин байх шаардлагатай. Д бол өөх тосонд хамгийн ихээр агуулагддаг. Хэрэв тухайн хүний ходоодонд өөх тос орж ирээгүй тохиолдолд хэчнээн их кальци хэрэглээд ч биед шингэлгүй гадагшилдаг байна. Тэгэхээр тослоггүй тараг, сүү хэрэглэлээ гээд танд наалдаж үлдэх зүйл байхгүй л гэсэн үг.

Монголчуудын эрүүл хооллолтын талаарх ойлголт нэг үеэ бодоход нэлээд өөрчлөгдсөн. Аль болох зөв идэж, уух, зөв хэв маягаар амьдрахыг эрмэлзэх болсон нь илт. Харамсалтай нь, тэр нарийн мэдлэгийг олгох боломж ховор, элдэв ном товхимол, сэтгүүлээс өөрсдөө мэдээлэл олж авдаг ч тэр болгон ашиглахгүй байгаагаас өвчлөл буурахгүй, өссөөр байгаа юм. Энэ бол халдварт бус өвчин буюу зүрх судасны өвчин, чихрийн шижин, таргалалт болон хорт хавдар. Эдгээр нь буруу хооллолттой шууд хамааралтай болохыг Александр Мартынчук онцолсон. Тэгвэл манай улсад энэ төрлийн өвчлөлийн тоо ямар аюултай хэмжээнд хүрээд буйг цөөхөн тоо баримтаар тодотгоё.

Монгол Улсын 30-70 насны иргэдийн 32 хувь нь наснаасаа эрт буюу халдварт бус өвчнөөр нас барж буйг ДЭМБ-аас тогтоосон. Энэ нь бүс нутагтаа дээгүүрт тооцогдож байна. Тодруулбал, нийт нас баралтын 72 хувь нь халдварт бус өвчнөөс шалтгаалж байна. Тэр дундаа 70-аас доош насны эрэгтэйчүүдийн 69.2, эмэгтэйчүүдийн 54.7 хувь нь ийн цаг бусаар хорвоог орхиж байгаа нь Номхон далайн баруун бүсийн орнууд дундаа халдварт бус өвчний тархалт өндөртэй орнуудын долдугаарт эрэмбэлэгдэх үзүүлэлт. Түүнээс гадна Монгол Улсын 15-64 насны хоёр хүн тутмын нэг нь илүүдэл жинтэй байгаагийн 70 хувь нь буруу хооллолттой холбоотой болохыг Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгээс тогтоосон.

Хамгийн ноцтой нь мэдээж хорт хавдар. Ялангуяа, элэгний хорт хавдрын 100 мянган хүн тутам дахь үзүүлэлтээрээ манай улс дэлхийн дунджаас найм дахин өндөр байгааг дурдахад л хангалттай байх. Сүүлийн жилүүдэд хүүхдүүдийн дунд энэ төрлийн өвчлөл нэмэгдэж байгаа нь анхаарал татах асуудал. 0-4 насны 100,000 хүүхэд тутмын дөрөв, 5-9 насны хүүхдүүдийн тав, 10-14 насны хүүхдүүдийн долоо нь, 15-19 насны хүүхдүүдийн 12 нь ямар нэг төрлийн хорт хавдраар өвчилсөн нь бүртгэгдсэн байдаг. Энэ бүхэн таны ам руугаа хийж буй бүхэнтэй, амьдралын хэв маягаас үүдэлтэй гээд бодохоор харамсалтай. Халдварт бус өвчин манай улсад ийнхүү маш өндөр байгаа нь яваандаа эдийн засагт ихээхэн дарамт болохыг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Банкок дахь судалгааны багийн ахлагч Надиа Рашийд Монголд энэ чиглэлээр судалгаа хийхээр өнгөрсөн сард ирэхдээ анхааруулсан. Монголчуудын гадны орнуудад эмчлүүлэхэд зарцуулж буй мөнгө хамгийн багадаа 58 сая ам.доллараар хэмжигдэж буй. Энэ бол зарцуулахгүй ч байж болох байсан мөнгө гэдгийг сануулах хэрэгтэй болов уу.

> » Монгол Улсын 30-70 насны иргэдийн 32 хувь нь наснаасаа эрт буюу халдварт бус өвчнөөр нас барж буйг ДЭМБ-аас тогтоосон.
>
> » Монгол Улсын 15-64 насны хоёр хүн тутмын нэг нь илүүдэл жинтэй байгаагийн 70 хувь нь буруу хооллолттой холбоотой.
>
> » Халдварт бус өвчнөөр нас барж буй тоогоороо Номхон далайн баруун бүсийн орнуудын долдугаарт эрэмбэлэгдэж байна.

“Ганц амьдрах юм чинь иддэгээ идээд, уудгаа уугаад дуусна” гэх хандлага манайд нийтлэг. Харин иддэгээ идэж, уудгаа уусаар нэг л өдөр илүүдэл жинтэй иргэдийн тоонд орж, өвчтөн болсон хойноо та харамсахад дэндүү оройтсон байж мэднэ. Таргалалт бол хорт хавдраар өвчлөгсдийн нэг болох эхний шат. Өнөөдөр бид эрс, тэс уур амьсгалд нүүдэллэж, малынхаа араас өдөр шөнөгүй явдаг хуучны хэв маягаар амьдраагүй. Өдрийн ихэнх цагийг ажлын ширээний ард компьютерын дэлгэц ширтэж, кэйбордтой ноцолдож өнгөрөөнө. Орой нь зөөлөн буйдандаа шигдэж, зурагтын удирдлага эргүүлдэн өнгөрөөж буй өнөөгийн хэв маягт өвөг дээдэс шигээ идэж, уух нь бидэнд зохихгүй. Энэ хэв маягтаа нийцүүлэх гэж өдрийн хоолоо хам хум идэх нь бүр ч муу болохыг А.Мартынчук тэмдэглэсэн.

> **Монголчууд гадны орнуудад эмчлүүлэхэд 58 сая ам.доллар зарцуулдаг**

Тэр хоол хэдийгээр оливын тосоор хачирласан шинэ ногооны салат, гурвалжин будаа, жигнэсэн үхрийн мах байгаад ч нэмэргүй. Та яаруу сандруу идсэн л бол хор. Учир нь хоол ходоодонд орж эхэлснээс тодорхой хугацааны дараа ходоодны хүчил болон хоол боловсруулах бодис ялгаруулах дохиог тархинаас өгдөг аж. Бас “Одоо цадлаа” гэсэн мэдээлэл ч тархинд очих тодорхой хугацаатай. Харин энэ бүх үйл явц өрнөхөөс өмнө та хэдийнэ хэт их зүйл идчихсэн бол хоол биш, хор болдог ажээ.

Тэгэхээр хүссэн хүсээгүй ам руугаа хийж буй бүхнээ ухамсартайгаар сонгож, илчлэгийг тооцдог болохоос л өөр аргагүй гэдгийг хоол тэжээлийн хөгжил харуулж байна. Үгүй бол та бид ирээдүйн өвчтөнүүдийн эгнээг тэлэхээс цаашгүй нэгэн болж хувирах нь. Энэ бол бидний буруу хэвшлийн төлөөс. [ЗГМ]

Баярын мэндчилгээ

Монгол Улсад орчин үеийн эмийн үйлдвэрлэл, хангамжийн алба байгуулагдсаны 93 жилийн ой, Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн “Эм” холбооны 20 жилийн ойн баярын мэндчилгээг ард түмнийхээ эрүүл мэндийн төлөө авьяас мэдлэг, хүч хөдөлмөрөө зориулан эмийн үйлдвэрлэл хангамжийн салбарт цуцалтгүй хөдөлмөрлөж байгаа үе үеийн нийт эм зүйч, эм найруулагч, ажилтнууддаа дэвшүүлж аз жаргал, амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөе.

Монголынхоо ард түмэндээ мөн энэ ялдамд жаргал жаргалын дээд эрүүл энхийг хүсэн ерөөе.

Одоогоос 20 жилийн өмнө "Монос", "Нахиа", Биобэлдмэлийн үйлдвэр, Эмийн үйлдвэр зэрэг 10 гаруй байгууллага хамтран Монголын эм үйлдвэрлэгчдийн холбоог үндэслэн байгуулж байсан бол эдүгээ мянга гаруй эмийн сан, 50 гаруй эм ханган нийлүүлэх байгууллага, 30 гаруй эмийн үйлдвэрийг эгнээндээ нэгтгэсэн Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн “Эм” холбоо болон өргөжиж ард түмнийхээ эрүүл мэндийн төлөө Эрүүл мэндийн яамтайгаа гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

Тус холбоо гишүүн байгууллагуудынхаа эрх ашгийг хамгаалан, тэдний үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мэргэжлийн болон санхүүгийн чадавхийг дээшлүүлэх талаар олон төрлийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулдаг боллоо. Жил бүр эм эмнэлгийн тоног төхөөрөмжийн үзэсгэлэн, эмч эмзүйчид, эмнэлгийн ажилтнуудын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх сургалт семинарыг зохион байгуулж байна. Монголын эм зүйн ажилтны өдрийг бүй болгож 15 удаагаа тэмдэглэхийн зэрэгцээ Монголын эмийн үйлдвэрлэл, хангамжийн тэргүүний ажилтан тэмдгийг бүй болгож, тус салбарт ажиллаж буй олон зуун тэргүүний ажилтныг урамшууллаа. Монгол Улсад орчин үеийн эм хангамжийн алба байгуулагдсаны 75,80,85,90 жилийн ойг тус холбоо гардан зохион байгуулсан бөгөөд тус салбараас эрүүлийг хамгаалахын дөрвөн гавьяат төрснийг тэмдэглэхэд таатай байна.

Монголын эмзүйчдийн анхдугаар их хурлыг тус холбоо санаачлан зохион байгуулсны зэрэгцээ төрөөс эмийн талаар баримтлах бодлого, эмийн тухай хуулийг боловсруулах, удаа дараа шинэчлэх, хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцлоо.

Тус холбооноос зохион байгуулж байгаа олон төрлийн ажил, эмийн үйлдвэрлэл, хангамж, үйлчилгээний салбарт ажиллаж буй олон мянган ажилтны цуцашгүй ариун хөдөлмөрийн үр дүнд тус салбар эрчимтэй хөгжиж байна. Одоо манай ард түмэн Америк, Швейцарь, Англи зэрэг дэлхийн 40 гаруй орны Пфайзер, Санофи, Глаксо зэрэг алдартай 150 гаруй пүүсийн эмийг хэрэглэх боллоо. Эмийн үйлдвэрлэлийн олон улсын стандарт хангасан "Айвико", "Монос" зэрэг үйлдвэрүүдтэй болж, эх орныхоо нийт хэрэгцээт эмийн 25 хувийг дотооддоо үйлдвэрлэх боллоо. Өргөн сонголт бүхий олон мянган нэр төрлийн эм бэлдмэл төдийгүй, хүүхэд, өвчтөн асрах бараа, ариун цэвэр, гоо сайхны зэрэг тасагтай орчин үеийн эмийн сангууд хүн амд хөнгөн шуурхай үйлчилж байна.

Ард түмнээ эм,вакцин, био бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр үйлчлэх ариун үйлстээ улам их амжилт гаргахыг эмийн үйлдвэрлэл хангамжийн салбарт ажиллаж буй нийт эмзүйч, эм найруулагч, ажилтан ажилчдад хүсэн ерөөе.

Монгол Улсын төрийн шагналт, эм зүйн ухааны доктор, профессор, Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн “Эм” холбооны хүндэт ерөнхийлөгч Л.Хүрэлбаатар

Өдөр бүр Танд



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИН ХМХ
FT FINANCIAL TIMES

Блю Скай тауэр, 4 Давхар, № 407, Энхтайваны өргөн чөлөө 17, 1-р хороо
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс, И-мэйл: info@zasag.co
Утас: +976 70103131, Факс: +976 70106065, Вэб: Zasag.Co

Судлаачийн үг

Ганцхан дүгнэлт: Ирак Ираных боллоо

Америкчуудын хүсээгүй холбоотон нь өөрсөдтэй нэг нуувчинд орчихсонд гайхаад баршгүй

Олхонуд Баярхүү
Олон улсын харилцааны профессор

BBM©

Дэлхийн мэдээллийн их урсгал дотор Сири, Иракаас гэгээтэй гэхээсээ баргар агуулгатай мэдээ голлоно. Гэхдээ лав Иракт "Лалын улс" (ISIL) бүлэг үндсэндээ ялагдаад дууcч байгаа бололтой. Иракийн хоёр дахь том хот Мосул 2014 оны зунаас "Лалын улс" гэх халифатын нийслэл байсан, 2016 оны хавраас Иракийн арми тэр хотыг бүслэн хааж, байлдаж буй. Ялагдлаа мэдэрсэн исламистууд тэндээс дүрвэсээр. Өнгөрсөн зун Халифатын халиф нь зугтаад алга болсон. Америк тэргүүтэй олон үндэстний хүчнийхэн хүч хавсраад мөд энэ хотыг чөлөөлчихнө. Гэлээ гээд амар амгалан үе Иракт ирэхгүй гэх өөдрөг бус төсөөлөл гадаадын хэвлэлээр түгээмэл.

Яагаад? "Лалын улс"-ыг цэрэгдайны талаасаа ялж болох юм. Гэтэл тэр дайны дараа Иракт юу үлдэх вэ гэдэгт л зовинол орших байх шиг. Иракийн нийгмийн конфигурац (configuratio) ямар болох вэ? Конфигурац гэдгийг нийгмийн харилцаа, нийгмийн төлөв байдал гэж буулгаж болно. Шашнаараа талцаж хуваагдсан Ирак бахь байдгаараа л үлдэнэ. Энэ бол конфигурац нь мөн.

Хэрэв "Лалын улс" дарагдаж гэмээнэ хэн ялагч болж үлдэх вэ гэдэгт хамгийн их адармаа оршиж байна. Хуваагдсан олон шашны дотроос лалын шиитийн сайн дурын хүчин ("Ардын дайчилгааны цэрэг" буюу арабаар "Хашд шааби") Иракийг захирч үлдэх төлөв харагдана. Энэ бол Ираны цэрэгжсэн элит-Лалын хувьсгалыг хамгаалах корпусын салаа салбар нь болчихоод, цаашаа төлөвшиж байгаа цэргийн томхон бүлэг юм. "Ардын дайчилгааны цэрэг" гэдэгт персүүд олуулаа байгаа нь америкчуудыг хилэгнүүлсэн нэг гол шалтгаан болно. Жихадистуудаас Иракийг хамгаалж байгаа нь сайн хэрэг. Гэхдээ л хожим үлэмж гай тарьж мэдэх шиитийн хүчирхэг бүлэглэл болж хувирчээ. Америкийн "The National Interest" сэтгүүлд бичсэнээр, 100 мянган шалгарсан цэрэг Иракт байлдаж байлаа гэхэд 80 хувь Ираны лалын хувьсгалыг хамгаалах корпустой ямар нэгэн холбоо сүлбээтэй. 2017 онд Иранд сонгууль болно, тэгэхэд Тегеранд ч, Багдадад ч эрх мэдлийн оргилд энэ 100 мянгаас олон хүн хүрсэн байх тооцоотой. Иракийн зарим хотод Ираны дээд лидер аятолла Хаменеи, түүний өмнөх Хомейни нарыг том том хөргийг өлгөөд эхэлсэн нь нэгийг өгүүлэх шиг.

Мосул руу 1) шиитийн хүчнийхэн, 2) америкийн цэрэг, 3) Иракийн Засгийн газрын цэрэг нэгдэн чөлөөлөлт явуулж байна. Америкчуудын хүсээгүй холбоотон нь өөрсөдтэй нэг нэг нуувчинд орчихсонд гайхаад баршгүй. Учир нь "Ардын дайчилгааны цэрэг" буюу нөгөө 100 мянга дотор чинь террорист гээд Вашингтонд бүртгэгдчихсэн маш олон нөхөр хамт мөр зэрэгцэн тулалдаж байна. "Ардын дайчилгааны цэрэг"-ийн командлагчийн орлогч Абу Махди аль-Мухандис бол өөрийн "Катаиб Хезболла" гэх зэвсэгт отрядтай, тэр нөхөр террористуудын жагсаалтыг магнайлна. "Foreign Policy" сэтгүүлд судлаач Майкл Найтсын бичсэнээр, тээр жил Иракийг Саддамын дэглэмээс чөлөөлсний дараа Америкийн маш олон цэрэг дайчдыг хөнөөсөн хэрэгт энэхүү "Катаиб Хезболла" буруутай аж.

"Ардын дайчилгааны цэрэг" ч тэр, дотор нь буй "Катаиб Хезболла" ч тэр, Ираны эрх ашгийг үхэн хатан хамгаалахын сацуу олон улсын хүний эрхийг хамгаалагчдын (Human Rights Watch гэх мэт) гомдоллож байгаагаар лалын суннит шашинт хүн ам голлосон хот, тосгодод айхтар хэрцгий хандлаг, элдэв эрүү шүүлт тулгадаг, ер нь яргалаад дуусдаг юм байх. "Лалын улс"-тай хардсан л бол амьд гарах суннит хүн олдохгүй. Курдын пешмерга гэх сайн дурын цэрэг чөлөөлсөн хот тосгодоо "Ардын дайчилгааны цэрэг"-т шилжүүлж өгсний дараахнаас гай гамшиг нүүрлэнэ.

Ингэхэд "Ардын дайчилгааны цэрэг" гэдгийг Иракийн эрх баригчид армидаа хүч хавсруулахаар байгуулсан. Гэтэл нэг мэдэхнээ энэ цэргийн гол хүч нь Ираны тал баримтлагчдаар дүүрчээ. Энэ хүчний гол гол тушаалд Ираны гол агент болох "Бадр" гэх бүлгийнхэн морилж байна. Ер нь Иракийн арми, цагдаад "бадрчууд" маш олуулаа. Иракийн Ерөнхий сайд Хайдер аль-Абади нь "Бадр"-ын лидер Хади аль-Амири гэгчтэй бат зузаан барилдлагаатай. "Ардын дайчилгааны цэрэг" дэх "бадрчууд" (нэг ёсондоо шиит шашны фанатууд) хэт оодроод одоо тэднийг Иракийн Засгийн газар хянаж хүчрэхгүй болсонд жирийн иргэд нь ихэд шаналан сууна.

Эндээс үзвэл "Ардын дайчилгааны цэрэг" гэдэг нь нэгдсэн командлал, нэгдсэн сахилга бат, итгэл үнэмшилгүй, нэгдсэн зохион байгуулалтгүй зэвсэгт бүлэглэл юм шиг. "Foreign Policy"-д Ренад Мансур гэгчийн бичсэнээр Иракаас "Лалын улс" хөөгдөн гарсны дараа энэ бүлгийнхэн Иракийг түйвээж мэдэхээр юм. Харин эдэнтэй хэрхэн учраа олно доо гэх хүлээлт, бүр айдас Вашингтонд төлөвшин буй. Ирак нь лалын шашны хоёр том урсгалын хоорондын дайнд цаашаа автана. Иран нөлөөтэй болж ирнэ, Ирак Ираных болно гэхээс америкчууд голдоо ортол мэгдэн сандарч байх шиг. Иракт байлдаж явсан, эдүгээ Конгрессын гишүүн Сет Мултон энэ тухай зовинолтойгоор ярьжээ.

"Ардын дайчилгааны цэрэг"-ийг шашны нөлөөллөөс гаргая, суннитуудыг тийшээ түлхүү оруулъя, тэгэхгүй бол дарагдашгүй том дайснаа харсаар байж бэхжүүлчихнэ хэмээн тэрээр сануулаа. Улстөрч Мултоны үзэж байгаагаар, Мосулыг чөлөөлөх гэж яаравчлах хэрэггүй, Иракийн Засгийн газарт мөнгөөр туслахдаа "Ардын дайчилгааны цэрэг"-ийн нөмөр нөлөөнөөс сална гэсэн ам өчиг ав, армийг араб-суннитуудаар түлхүү удирдуул гэхчлэн уриалан дуудсан байх юм.

Гэтэл шиитийн сайн дурынхан өөдөөс нь "хуц" гэнэ. Шийддэгээ шийдчихсэн, хийдгээ хийчихсэн, америкчууд хориглоод нэмэргүй хэмээн ам таглав. "Америкчууд харин бидэнд баярлалаа гэж хэлэх хэрэгтэй. Яагаад гэвэл бид байгаагүй бол "Лалын улс"-ын довтолгооныг бид эхлэн няцаагаагүй бол яах байсан хэрэг вэ? Бид энд ганц Иракийг биш, бүх дэлхийг хамгаалж байна шүү дээ!"-шиитүүдийн дайчин цогтой үгс энэ.

Явж явж Иракт Иран гэж нэг том ялагч гараад ирэхээр дүр зураглал бууж байна. Америкчууд Саддамыг зайлуулсныхаа дараа хүн амын олонх нь юм гэж тооцоолоод шиит Ерөнхийлөгч Иракт томилохыг оролдсон. Гэм нь теократ шиит Иран ихээхэн дургүйцсэн. Аятоллатай зэрэгцэх шиит Төрийн тэргүүн зэргэлдээх Арабын улсад гараад ирнэ гэдэг тэдний лалын хувьсгалын зарчимд нийцэхгүй. Тэгэхээр нь ардчилсан сонгууль явуулсан дүр эсгээд, шиит Ерөнхий сайд Нури аль-Малик гэгчийг гаргаад ирсэн. Иран тэр үед үндүүцаагүй. Сирийн иргэний дайн дэгдсэний дараа Иракийн агаарын орон зайг Дамаск-Тегераны хооронд нээгээд өгчээ. Нэг талаас нь цэргийн зөвлөхүүд, зэр зэвсэг, сум агаараар зөөвөрлөсөн. Эргээд шархтанууд Ираны эмнэлгүүдийг дүүргэсэн юм.

Иракийн шиитийн шашны удирдагч Моктад ас-Садр Иранд ихэнх цагаа өнгөрөөсөн, тэнд суралцсан, дайчид нь Сирид одоо хүртэл байлдаж байна. Багдадын шиитийн хорооллуудад Ираны аятолла, Иракийн имам Садрын зураг зэрэгцэн өлгөөтэй өнөөг хүрлээ. Аль нь жинхэнэ удирдагч вэ? Ийм зураглал сүүлийн хэдэн жил нүднээ буулаа. Одоо Мосулыг чөлөөлж байна. Тэнд Ираны сайн дурынхан, шиитийн босогчид, курдууд, Америкийн хэдэн зуун цэрэг, Иракийн албан ёсны арми хамт очлоо.

Шиит Ерөнхий сайдын балгаар Ирак орон эхлээд хаост орсон. Суннитууд бүр ч хүнд байдалд орсон. Тэднийг хамгаалах нэрээр "Лалын улс" халифатаа байгуулж, аллага үйлдэж, бас газрын тосыг нь үлэмж цөлмөсөн. Гэтэл дэргэд нь Курдистан шиг цэцэглэн хөгжсөн бүс нутаг, тэндхийн диваажинг гэмгүй маш олон Иракийн суннит мөрөөдөн суугаа. Хэд хэдэн суннит омгууд Багдадын эрх баригчдын эсрэг бослого дэгдээхийн тулд дайчилгаа зарлаж үзэв. Обейд, Жабур хоёр омог зөвхөн зэвсэгт тэмцлийн зам сонгоно гэж заналхийлсэн. Цаашаа яах вэ? Гадаадын хэвлэл мэдээллийн үнэлэлт дүгнэлт бүр баргар төсөөллийг хэлээд байх шиг. Хоёр л зам Иракийг хүлээж байна. Шашин хоорондын сунжирсан цуст дайн бүр жинхэнээсээ дэгдэх; Ирак улс хэдэн хэсэг болж задрах. Энэ хоёроос гадна бүр хамгийн баргар гурав дахь зам байна. Дээрх хоёр замыг хослуулах буюу эртний, нөлөө бүхий, түүхт Ирак орон бүрэн дампууран нурж унах зам. Энд гарцын тухай биш сценар ярьж байна.

Иракийг тойрсон Баруун өмнөд Ази тэр чигтээ шиит, суннитуудын мөргөлдөөний хөлд дайрагдах цаг айсуй юм биш биз? Бүр 20-30 жил үргэлжлэх шашны дайны тухай ёрлон ярьдаг болжээ. Сектант дайны газрын зураг дээр бүлэг орнууд эчнээ зоогдоод байна. Иракаас эхэлсэн тогтворгүй байдал Сирид эргэж тархах, Ливаны хувь заяа буруугаар эргэх, Иордан, Иран, Ливи, Туркэд бужигнах нигуртай. Хэдийгээр айхтар цус урсгаж бужигнахгүй ч шашны мөргөлдөөн Бахрейн, Саудын Арабыг хөндөж мэднэ. Катарыг энэ жагсаалтад нэмж болно. Тэртэй тэргүй Йемен нураад унaчихсан. Энэ мэтээр маш олон улс орон XXI зууны энэ торгон агшинд шашны цуст мөргөлдөөний гэрч болох юм биш байгаа?

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИН XMX

"Засгийн газрын мэдээ" сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН
Тэргүүн орлогч эрхлэгч
Цэвээндолгорын ЦЭВЭЭНХЭРЛЭН
Утас: 99901526
Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦИ

Улс төр, нийгмийн мэдээллийн алба
Эдитор Б.Гандолгор
Утас: 99901483
Эдийн засаг, бизнес мэдээллийн алба
Эдитор Р.Оюунцэцэг
Утас: 99901621
Гадаад контент, соёл энтертайнментын алба
Эдитор Б.Энхжаргал
Утас: 99901682

ЗАР СУРТАЛЧИЛГАА
Г.Лхагвасүрэн
Утас: 99903581

ХАЯГ
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,
"Блю Скай тауэр" 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар: 1024
Утас: 70103131,
Факс: 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР
Zasag.Co
"Чөлөөт хэвлэл"
сангийн хэвлэх үйлдвэрт хэвлэв
Дугаарын удирдагч
Б.Гандолгор

8658000029112 00500

СУДАЛГАА

Монгол ажилтнууд бүтээмжийн хомсдолд орсон

Г.Сайнзаяа
@sainzayaZGM

Хүний нөөцийн зөвлөх компани "NPC Мандал" сүүлийн гурван жилд Монголын 40 гаруй байгууллагын 3000 орчим ажилтны сэтгэл зүйд судалгаа хийжээ. Ингэхэд тэд бүтээмжийн дутагдалд орсон, нөөц бололцоогоо бүрэн ашигладаггүй болох нь тогтоогдсон байна. Энэ нь монгол ажилтнуудын дадал зуршил, сэтгэл зүйн байдал болоод сэтгэхүйн онцлогоос шалтгаалдаг аж.

Монгол Улсад хөдөлмөр эрхэлдэг, татвар төлдөг 630 орчим мянган хүн бий. Өөрөөр хэлбэл, нэг хүн дунджаар таван хүнийг тэжээдэг гэсэн ерөнхий дүр зураг гарна. Харин идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 30 мянган аж ахуйн нэгж байгаа. Харамсалтай нь, эдгээр байгууллага ажилтнуудынхаа сэтгэл зүйн байр байдал, ур чадварыг төдийлөн чухалчилж үздэггүй аж. Улмаар ажил олгогчид сүүлийн үед аливаад сэтгэл гаргадаг, зөв хандлагатай хүмүүсийг ажилд авахыг эрмэлзэх болжээ. "NPC Мандал" компанийн гүйцэтгэх захирал Ц.Энхжаргал "Захирлууд, хүний нөөцүүд "Ажилтнуудаа техникийн ур чадварыг явцын дунд зааж сургаж болно оо. Гэвч сэтгэл, ёс суртахуун, багаараа ажиллах төлөвшилтийг суулгаж чадахгүй байна. Ийм хүн хаанаас олох вэ" гэж халагладаг болсон" гэв.

Дийлэнх компани ажилтан шалгаруулж авахдаа IQ-г нь чухалчилдаг. Үнэн хэрэгтээ IQ өндөртэй ажилтнууд 2-3 жилийн дараа ажлаас халширч, бүтээмж нь 60 хувь хүртэл буурдаг гэсэн судалгаа бий. Энэ нь ажилтны оюун ухааны чадвараас илүүтэй ажиллах дадалд суурилсан чадвар илүү чухал гэсэн үг юм байна.

Сэтгэл хөдлөлийн удирдах чадвар буюу EQ-г IQ-Оюун ухааны чадвараас илүү гэж сүүлийн үед эрдэмтэд дуу нэгтэйгээр хэлэх болов. Учир нь EQ өндөртэй ажилтнуудын өөрийгөө тогтмол хөгжүүлэх чадвар бусдаас гурав дахин өндөр. Багийн гишүүдтэй эерэг харилцаатай, эхний жилдээ ажлаас гарах магадлал IQ өндөртэй хүмүүсээс 63 хувиар бага байдаг. Мөн бусдаасаа 139 хувиар илүү орлогыг байгууллагатаа оруулдаг гэж үзжээ.

"NPC Мандал" компанийн судалгаанаас үзвэл сэтгэл гутралд өртсөн монгол ажилтнуудын ердөө 12 хувь нь бусадтай ярилцах байдлаар сэтгэл зүйн дэмжлэг авдаг байна. Харин 88 хувь нь түр зуур "гал намжаах" арга хэмжээ авдгийг тогтоожээ. Үүнд, сөрөг бодлууд нь давамгайлж, идэвхгүй, дотогшоо болох, архи, тамхины хэрэглээ нэмэгдэх, бусдыг буруутгах, сөрөг үйлдлүүд хийх, гэртээ оройтож харих, маргалдах зэрэг багтана.

Хүн эрч хүчээ олон зүйлд тэгш хуваарилах ёстой байдгийг сэтгэл судлаачид хэлдэг. Монгол ажилтнууд өдөрт дунджаар 10 цаг ажилладаг бөгөөд 40 хувь нь дутуу нойртой явдаг юм байна. Мөн өглөө ажилдаа 100 хувийн эрч хүчтэй ирдэггүй. Үүнийг гар утасны цэнэгээр жишвэл 70-80 хувийн цэнэгтэй ирээд 10 цагийн дараа гэхэд тэг хувь болдог. Улмаар гэртээ очоод эхнэр, нөхөр, хүүхдүүддээ зарцуулах эрч хүчгүй болж, тэднээс дөлөх хандлагатай болно. Энэ нь уур бухимдал тайлагдахгүй байх бас нэг шалтгаан ажээ. Тиймээс өдөрт найман цаг унтаж, зөв хооллон, хөдөлгөөнөөр хичээллэвэл байгууллагын нийт ажилтнуудын бүтээмж сайжрахыг Ц.Энхжаргал зөвлөсөн юм.

Үүнээс гадна монгол ажилтнууд стресст орсон ч "Энэ миний л асуудал" гэж боддог учир бусадтай хуваалцдаггүй. Ц.Энхжаргал "Стрессээ тайлаагүйн улмаас хүн уур бухимдалтай болж, үүнийгээ зарим цаг үед, жишээ нь найр наадмаар "дэлбэлж" гаргадаг. Өнгөрсөн зүйл ярьж, тэсэрдэг гэсэн үг. Энэ нь цаг үеэ ч олдоггүй, үр ашиггүй үйлдэл болж хувирдаг" хэмээв. Манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн дийлэнхийг 30-40 хүнтэй байгууллагууд эзэлдэг. Харамсалтай нь, компаниудын дийлэнхэд стрессийн орчин давамгайлдаг аж. Энэ нь сэтгэл гутралыг тайлах биш, улам өргөжүүлж буглуулж байдаг орчныг хэлнэ.

Дашрамд дуулгахад, өнгөрсөн хугацаанд тэдний хийсэн судалгаагаар монгол хүн асуудалтай гэдгээ хүлээн зөвшөөрдөггүй. Түүнтэйгээ нүүр тулах дургүй, өөрийгөө сатааруулах замаар асуудлаас нүүр буруулдаг болохыг тогтоожээ.

Ажилтнуудын энэ мэт сэтгэл зүйн асуудлуудыг шийдсэнээр байгууллагын ашиг орлого, насжилт нэмэгдэх, хүний нөөцийн зардлыг үр бүтээлтэй ашиглах зэрэг олон давуу талтай. "NPC & Мандал" компани ажилтнуудын сэтгэл зүйг засах, бэлдэх ажлыг гүйцэтгэн туршилтын шатандаа явж байна. Ц.Энхжаргал "Ажилтнуудынхаа сэтгэл зүйг хэрхэн удирдах, эсэх шийдвэр захирлуудад бий. Гэвч үүнийг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байна. Тиймээс бид захирлууд, хүний нөөцийн менежерүүд, удирдах албан тушаалтнуудад зориулсан "Байгууллагын сэтгэл зүйн удирдлага" хэлэлцүүлгийг энэ сарын 22-нд хийх гэж байна" гэлээ. [ЗГМ]

Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

The Swiss Agency for Development and Cooperation (SDC) is Switzerland's international development and cooperation agency withing the Federal Department of Foreign Affairs.

To find our more information, please refer to our website:

www.eda.admin.ch/mongolia

VACANCY NOTICE

Head of Project Coordination Unit
Green Gold/Animal Health Consolidation Project (2017-2020)

The Swiss Agency for Development and Cooperation (SDC) in Mongolia seeks to hire a highly motivated professional as Head of Project Coordination Unit for its Green Gold/Animal Health Consolidation Project to be implemented during the period January 1, 2017 - December 31, 2020. SDC invites highly motivated and competent professionals to apply for the vacant post.

We offer:
- A position as Head of Project Coordination Unit to lead the project coordination unit, based in Ulaanbaatar
- An opportunity to work in a highly relevant project (sustainable rangeland management, improved marketing of livestock products and better animal health services)
- Good working conditions, attractive compensation package and opportunities for further professional development

What you bring:
- Master and/or PhD degree in agriculture, economy, animal health, environment or related field
- At least 5 years working experience in development projects at a managerial level
- Capacities in result based project management and experiences in policy dialogue
- Strong coordination and communication abilities with proven analytical skills
- Capacities to deliver results on time and experiences in administration and finance
- Capacities to motivate staff and partners, and abilities to lead a team and to steer and coordinate a high number of partners
- Availability for frequent travels in rural areas
- Excellent written and spoken communication skills in both English and Mongolian

Applications:
Candidates are invited to submit a Curriculum Vita, including at least 3 recent references and copies of certificates plus a Motivation Letter explaining an interest for the position electronically to the following address: ulaanbaatar@eda.admin.ch by mentioning the project and the position no later than 11th of November 2016. Only short-listed candidates will be contacted. No additional information will be provided via telephone or emails.

ЗГМ: Сурвалжлага

Төрийн "супермаркет"-ын эзгүйрэл

Ингээд тооцохоор нийслэлийн төсвөөс сард 114 сая төгрөг гаргадаг

Б.Бямбасүрэн
@byambaZGM

“Гадаад паспорт захиалахаар Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн "Мишээл экспо" дахь салбараар очив. Бэлдэц дууссан шалтгаанаар захиалга авсангүй. Нэгдсэн төвийн танхим саруулхан, том талбайтай, төрийн бүх үйлчилгээ нэг дор төвлөрсөн байна лээ. Гэсэн ч төрийн албан хаагчдаас өөр хүн харагдсангүй. Хүмүүс мэдэхгүй болохоор очихгүй байгаа байх” хэмээн танил маань өгүүлэв. Тиймээс сүр дуулиантай эхэлсэн төрийн үйлчилгээний хамгийн том супермаркетын үйл ажиллагаа хэрхэн явж байгааг сурвалжлахаар Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн "Мишээл", "Дүнжингарав" дахь салбарыг зорьсон нь энэ.

"Мишээл" барилгын их дэлгүүр дотор байрлах нэг цэгийн үйлчилгээний салбараар 11.30 цагийн үед очлоо. Үүдээр нь ормогц мэдээллийн ажилтан угтан авч, ямар үйлчилгээ авах хүсэлтэй байгааг минь тодруулав. "Мишээл" салбар бусад хоёрыг бодвол зай талбай багатай, цомхон байлаа. Гаднах зогсоолд нь 10 гаруй машин харагдлаа. Ажлын өдөр төдийгүй үдээс өмнө гэхэд үйлчлүүлэгч олон байгаа бололтой гэсэн миний таамаг зөрлөө. Дотор нь ороход тав, зургаа орчим хүн л үйлчлүүлж байгаа харагдав. Тэд голдуу халамж, улсын бүртгэлийн хэсгээр үйлчлүүлж байв. Харин бусад 15 гаруй цонх нь ямар ч хүнгүй, ажилтнууд нь компьютерынхоо ард сууж байв. "Мишээл" салбарын менежер Д.Байгалмаа “Манайх өнгөрсөн тавдугаар сарын 28-наас үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Нутгийн захиргааны 24 байгууллагын 236 үйлчилгээг нэг дороос үзүүлж байна. 89 албан хаагч хоёр ээлжээр ажилладаг. Үйлчлүүлэгчдийн тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа” гэв. Тус салбарыг өдөрт 3000 гаруй хүнд үйлчилнэ гэсэн тооцоогоор байгуулсан. Гэсэн ч өнөөдрийн байдлаар өдөрт дунджаар 600 орчим хүнд үйлчилж байгаа аж. Мягмар гарагт гэхэд 400 гаруй хүн тус төвөөр үйлчлүүлжээ.

С.Батсайхан / ЗГМ©

"Дүнжингарав" дахь салбарын хувьд арай өөр байв. Хэд гурван үйлчлүүлэгч явж байхтай таарвал ямартай ч хоосон биш байлаа. Тэд мөн л улсын бүртгэл, халамжийн үйлчилгээ, газрын харилцаа зэрэг өдөр тутам хүний амьдралд хэрэг болдог үйлчилгээ авахаар дугаарлажээ. Төрийн үйлчилгээг нэг дор төвлөрүүлж, зарим үйлчилгээний шийдэх хугацааг богиносгож, иргэдэд учирдаг байсан хүндрэл, чирэгдлийг халах зорилготой байгуулсан тус төвийн зарим албан хаагчдын зан араншин өнөөх л хэвээрээ хүнд сурталтай “пэдгэр” зантай нь харагдав. Зүдрүүхэн амьдралтай болов уу гэмээр хөгшин эр оочер дугаар авдагийг нь мэдэхгүй мэдээллийн ажилтнаас хэрэгтэй мэдээллээ асуухад өнөөх залуу “Цаашаа сууж байна. Би энд хүнтэй байна” хэмээн чанга дуугаар хэлсэн нь өнөөх эрийг агшин зуур бөндөлзүүлээд авлаа.

Цааш явж ажиглатал нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газрын гурван цонхны ердөө нэгд нь мэдээлэл өгөх хүн сууж байгаа харагдав. Тойроод өөр иймхэдэн газар байгаа эсэхийг харахад цөөнгүй хэсэг нь хоосон байв. Иин Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн хоёр салбараар ороход харьцангуй хүн багатай, зарим газар нь хоосорч, эзгүйрсэн байсан юм. Уг нь төрийн иймтом хэмжээний супермаркетыг ажиллуулж эхэлсэн нь төрийн албан хаагчдын хүнд суртлыг арилгах, авлигыг зогсоох

Иргэд төрийн үйлчилгээг авах гэж 100 тэрбум төгрөг зарцуулдаг байв

томоохон ач холбогдолтой. Өмнө нь иргэд хүнсний дэлгүүр байгуулах гэж мэргэжилтэн, дарга нарын үүдийг хэдэн өдөр сахиж, бичиг цаас бүрдүүлэх гэж нэг газраас нөгөө газар руу хоёроос доошгүй удаа явдаг байсан. Энэ үйлчилгээг эхлүүлэхийн өмнө нийслэлээс иргэд бичиг цаасны ажилд хэдий хэмжээний зардал гаргадаг болохыг судалж үзсэн байна. Ингэхэд нийслэлчүүд төрийн үйлчилгээг авах гэж шууд болон шууд бус зардалд 100 тэрбум төгрөг зарцуулдаг болохыг тогтоосон аж. Тиймээс энэ төвийг ажиллуулах шийдвэрийг нийслэлийн өмнөх удирдлагууд гаргаж, үүндээ бага биш мөнгө зарцуулжээ. Харамсалтай нь, нарийн тооцоо судалгаагүй хийсэн ажил өнөөдөр хэдэн зуун сая төгрөгийн үргүй зардал дагуулж буйг хатуухан хэлэх нь зүйтэй болов уу.

Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн "Мишээл" дэх салбарын талбай 1336 ам метр. "Мишээл" мега молл компани талбайгаа сарын 24 сая төгрөгөөр түрээслүүлдэг. Харин "Дүнжингарав" салбар 2800 ам метр талбайтай. Сарын түрээсийн төлбөр нь 60 сая төгрөгийн өртөгтэй. 1558 ам метр талбайтай "Драгон" дахь салбарын хувьд сарын төлбөр 30 сая төгрөг. Ингээд тооцохоор нийслэлийн төсвөөс сард нийт 114 сая төгрөгийг гаргадаг болж таарах нь. Дээрээс нь гурван салбарын хоёр ээлжээр ажилладаг нийт 300 гаруй ажилтны цалин нэмэгдэнэ. Төрийн албан хаагчийн дундаж цалинг 500 мянган төгрөгөөр тооцвол 150 сая төгрөг нэмэгдэхээр байна.

Уг нь 10 гаруй байршилд үйл ажиллагаа явуулж байсан газруудыг нэг дор нэгтгэж, төрийн үйлчилгээг хурдан шуурхай, хялбар, хүртээмжтэй болгосон сайн ажлуудын нэг. Гэхдээ эдийн засгийн хүндрэлтэй гээд бүхий л салбарт хэмнэлт хийж байгаа энэ үед энэ мэт үргүй зардлаа эргэж нэг хармаар юм. [ЗГМ]

ЗГМ: ТОДРУУЛГА

Төрийн албан хаагчдын орон тоог цомхон болгоно

Энэ талаар Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн дарга О.Мөнх-Оргилоос тодрууллаа.

-Танай төвийн үйл ажиллагаа ямар байна вэ. Нэмээд хоёр салбартай болсон. Үйлчлүүлэгчдын тоо хэр их байна вэ?

-Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн "Дүнжингарав" салбар нэг, "Мишээл", "Драгон" салбарыг дөрөвдүгээр сард байгуулсан. Энэ сарын 15-ны байдлаар нийслэлийн 800 гаруй мянган иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнээс "Дүнжингарав" салбарт 550, "Мишээл"-д 73, "Драгон" салбараар 170 мянган иргэн үйлчлүүлжээ. Өдөрт дунджаар гурван салбар нийлээд 3000-4000 иргэнд үйлчилж байна. Улирлаас шалтгаалан иргэдийн хандалт харилцан адилгүй байна. Жишээлбэл, оны эхний хагас жилд татварын байгууллагын ажил үйлчилгээ эрчимждэг бол найм, есдүгээр сард боловсролын газрын үйлчилгээ авдаг. Мөн гадаад паспортын үйлчилгээ үзүүлдэг байсан ч бэлдэц дууссан шалтгаанаар түр зогсоогоод байна. Гэхдээ иргэд асууж, сураглаж байгаа учраас бэлдэц нь ирсэн даруйд уг үйлчилгээг сэргээнэ.

-Гурван салбараар үйлчлүүлэгчдийн тоо нэлээд буурсан харагдаж байна. Улс орон даяар бүсээ чангалж байгаа энэ үед ажлын нөхцөл байдалтайгаа уялдуулан танай байгууллага зардлаа хэмнэх ямар нэг арга хэмжээ авч байна уу?

-Үнэндээ бидний тооцоолж байсан хэмжээнд хүмүүс үйлчлүүлэхгүй байгаа учраас ойрын хугацаанд бүтцээ цомхотгож, нэг ээлжээр ажиллахаар төлөвлөсөн. Тодруулбал, бүтэн 12 цагаар ажиллах нь хүн хүч, хөрөнгө санхүүгийн хувьд хүндрэлтэй асуудал үүсгэж байна. Иймд нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар энэ асуудлыг хэлэлцээд зардлын үр ашгаа тооцож, ажлын найман цагаар нэг ээлжээр ажиллахаар боллоо.

-Нийслэлийн 27 байгууллага, иргэдэд үйлчилж байна. Эдгээр байгууллагын хандалт харилцан адилгүй байдаг байх. Цөөн иргэдэд үйлчилдэг газруудад ямар зохион байгуулалт хийх вэ?

-Усын бүртгэл, газрын харилцаа, халамжийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын үйлчилгээг иргэд ихэвчлэн авдаг. Хандалт багатай ажил үйлчилгээ буюу өдөр тутам иргэдийн амьдралд хэрэг болдоггүй үйлчилгээнүүд мэдээж бий. Тухайлбал, эрүүл мэнд, боловсрол, худалдан авах ажиллагаа, даатгалын зарим үйлчилгээ багтана. Тиймээс ачаалал багатай байдаг 10 гаруй байгууллагын албан хаагчийг буцааж байна. Оронд нь буцаасан байгууллагын ажил үйлчилгээг өөр бусад газраар дамжуулан авдаг тогтолцоо руу шилжиж байгаа. Харин суларсан талбайд авто тээвэр, даатгал зэрэг иргэдийн хамгийн их үйлчлүүлдэг газруудыг оруулна. [ЗГМ]

TDB ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ УРИЛГА

Худалдаа, хөгжлийн банк нь дараах үл хөдлөх хөрөнгүүдийн дуудлага худалдааг 2016 оны 11-р сарын 22-ны өдрийн 11:00-13:00 цагийн хооронд өөрийн Төв байранд зохион байгуулна.

№	ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ	ХӨРӨНГИЙН БАЙРШИЛ	ХЭМЖЭЭ	ЗОРИУЛАЛТ	АНХНЫ ДУУДАХ ҮНЭ
1	Гандирс зочид буудал	Өмнөговь аймаг, Даланзадгад сум	4195.92 м.кв	Зочид буудал	4,000,000,000.00 /дөрвөн тэрбум/
		Газар	2734 м.кв		
2	Тайхар амралтын бааз	Булган аймгийн Орхон сумын 2 дугаар баг	1811 м.кв	Амралтын бааз	450,000,000.00 /дөрвөн зуун тавин сая/
		Газар	5,4 га		
3	Морьтхангай	Төв аймаг, Зуунмод сум	2592 м.кв	Үйлдвэрлэл	570,000,000.00 /таван зуун далан сая/
		Газар	2879 м.кв		
4	Галакси дунд сургууль	Баянгол дүүргийн, 17 дугаар хороо	411,6 м.кв	Сургууль, үйлчилгээ	390,000,000.00 /гурван зуун ерэн сая/
5	Үйлчилгээний зориулалттай барилга	Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороо,	1700 м.кв	Үйлчилгээ	770,000,000.00 /долоон зуун далан сая/
		Газар	472,25 м.кв	Гэр бүлийн хэрэгцээний	
6	Хувийн сууц	Баянгол дүүргийн 11 дүгээр хороо,	264 м.кв	Хувийн сууц	175,000,000.00 /нэг зуун далан таван сая/
		Баянгол дүүргийн 11 дүгээр хороо,	60 м.кв		
		Газар	217 м.кв	Гэр бүлийн хэрэгцээний	

Дуудлага худалдаанд оролцогч нь дуудлага худалдаанд оролцогчийн хураамж болон өөрийн сонирхож буй хөрөнгийн анхны үнийн 10%-тай тэнцэх дэнчинг байршуулснаар дуудлага худалдаанд оролцож үнийн санал гаргах эрхээ баталгаажуулна. Дэнчингийн мөнгийг Худалдаа, хөгжлийн банкин дахь 400496256001053 тоот дансанд 2016 оны 11-р сарын 21-ний өдрийн 17:00 цагаас өмнө шилжүүлсэн байна.

Жич: Дуудлага худалдаанд оролцогч иргэн 50,000.00 төгрөг, аж ахуйн нэгж, байгууллага 100,000.00 төгрөгийн хураамж төлөх ба энэхүү хураамжийг буцаан олгохгүй.

Нэмэлт мэдээлэл:

- Дэнчин тавьсан банкны гүйлгээний утга нь дэнчин тавьж буй хөрөнгийн "Хувийн дугаар" болон оролцогчийн "Овог нэр, регистерийн дугаар эсвэл хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар"-ын мэдээллийг агуулсан байх ёстой.
  Жишээ нь: "Хувийн дугаар 1, Овог нэр, РД"
- Дэнчингийн мөнгийг дээрх хугацаанд шилжүүлээгүй иргэд, аж ахуйн нэгж дуудлага худалдаанд оролцох боломжгүй болохыг анхаарна уу.
- Дуудлага худалдаан оролцогч нь дуудлага худалдаа явагдах удирдамжтай танилцсан байх. Удирдамжийг ХХБ-ны төв байрны ресепшинээс ирж авна уу

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө -19, Худалдаа, хөгжлийн банк, Улаанбаатар хот 14210, Монгол улс

Дуудлага худалдаатай холбоотой асуудлаар (Х.Мөнгөншагай, гар утас: 99003212, утас: 70100241, имэйл: mungunshagai.kh@tdbm.mn)-тэй холбогдоно уу.

Утас: 1900-1977 | **И-мэйл:** info@tdbm.mn | **Вэб хаяг:** www.tdbm.mn | **Фэйсбүүк:** www.tdbm.mn/facebook | **Твиттер:** www.tdbm.mn/twitter

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

БУЛГАН АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН ТУШААЛД ТОМИЛОГДОХ АЖИЛТНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЗАРЛАЖ БАЙНА

Шалгаруулалтын зорилго нь Булган аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын албан тушаалын сул орон тоог сонирхогч иргэдээс өрсөлдүүлэн шалгаруулж нөхөхөд оршино.

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН БҮРТГЭЛ

Сонгон шалгаруулалтанд өрсөлдөх иргэдийн материалыг Булган аймгийн Засаг даргын тамгын газрын 203 тоот өрөөнд **2016 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 09.00-13.00, 13.00-17.00** цагийн хооронд хүлээн авна.

Сонгон шалгаруулалтад орохыг хүссэн иргэн дор дурдсан материалыг бүрдүүлэн өөрийн биеэр ирж бүртгүүлнэ.

Үүнд:

1. Төрийн албан хаагчийн анкет (маягт № 1);
2. Боловсролын диплом, мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг нотлох бичиг баримтуудын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
3. Монгол Улсын иргэний үнэмлэх; /нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/;
4. Ажилласан жилийг тооцох Хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн эхний нүүр хуудсыг хөдөлмөрийн үйл ажиллагааны хөдөлгөөнийг баталгаажуулсан бусад хуудасны хуулбар, эх хувийн хамт;
5. Ажил байдлын тодорхойлолт;
6. 4х3-ийн хэмжээтэй 2 хувь цээж зураг. /1 ш нь анкет дээр наагдсан байх/
7. Бүртгэлийн хураамж 10.000₮

Дээрх баримт бичгийг дутуу бүрдүүлсэн иргэнийг бүртгэхгүй.

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ХУВААРЬ, ХУГАЦАА

2016 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр сонгон шалгаруулалтыг доорхи байдлаар зохион байгуулна.

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДСАН ШААРДЛАГА

	¯ç¿¿ëýëò	×óõàé ø ààðäëàãàòàé	Ø ààðäëàãàòàé
Åð°í õèé ø ààðäëàãà	Áî ëî âñðî ë	Áàêàëàâð áóþ ó ò¿¿í ýýñ äýýø	
	Ì ýðãýæèë	Í ÿãòëàí áî äî ã÷, ýäèéí çàñàã÷	
	Ì ýðãýø èë	Ì ýðãýø ñýí í ÿãòëàí áî äî ã÷	
	Òóðø ëàãà	Òº ðèéí àëáàí ä 10-ààñ äî î ø ã¿é, ¿¿í ýýñ 5-ààñ äî î ø ã¿é æèë õÿí àëòûí áàéãóóëëàãàä, 3-ààñ äî î ø ã¿é æèë óäèðäàõ àëáàí òóø ààëä àæèëëàñàí .	
	Óð ÷àäâàð	Áàãààð àæèëëàõ, î í î â÷òî é ø èéäâýð ãàðãàõ Êî ì ï üþ òåðèéí º ðãº í õýðýãëýýí èé ï ðî ãðàì ì óóäû ã àø èãëàæ÷àäààã áàéõ Ãàäààä õýëí èé çî õèõ ì ýäëýãòýé	Áàéãóóëëàãà õàì òî ëí û ã óäèðäàí çî õèî í áàéãóóëàõ
Òóñãàé ø ààðäëàãà		Òº ðèéí àëáàí õààã÷èéí ¸ñ ç¿éí õýì õýì æýýã ÷àí ä ñàõèõ, Õàðèëöààí û º í äº ð ñî ¸ëòî é, áóñäûã õ¿í äýòãýõ, Òº ð, áàéãóóëëàãà, õóâü õ¿í èé í óóöû ã õàäãàëàõ	

ЗУРГАА. МЭДЭЭЛЭЛ ЛАВЛАГАА

Сонгон шалгаруулалттай холбоотой асуудлаар Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn, Булган аймаг дах салбар зөвлөлийн 70342441, 96096326 утсаар холбогдож лавлагаа авч болно.

Ардчилсан намын үзэл баримтлалын шинэчлэл

Улс төрийн нам бол нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг баримжаатай, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх үзэл баримтлалтай, бодлогоороо өрсөлддөг институци. Хэрэв сонгуульд ялбал төрийн эрх баригч намын хувьд үйл ажиллагаагаа ч, дотоод засаглалаа ч олон нийтэд нээлттэй байлгах ёстой юм. Тиймээс л аливаа намын өөрчлөлт шинэчлэлт зөвхөн тухайн намд бус, нийгмийн нийт гишүүдэд хамааралтай өргөн хүрээний асуудал болдог. Үүнээс харахад Ардчилсан намын шинэчлэл сонгуульд ялагдсандаа, эрх баригчид нь гудамжинд гарсандаа л хийж буй шинэчлэл төдий бус харин сонгогчдын өгсөн үнэлгээнд дүгнэлт хийж нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзэл санааны нэг жигүүрийг баттай төлөөлж, иргэнийг төртэй холбодог бат бөх гүүр, тулхтай улс төрийн хүчний үүрэг гүйцэтгэж чаддаг байхын тулд хийж байгаа өргөн далайцтай шинэчлэл гэж хэлж болно.

НЭН ТҮРҮҮНД ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэгдүгээрт, Шинэчлэл юуны өмнө үзэл баримтлал, үнэт зүйлд нь тусах,

Хоёрдугаарт, Хөгжил дэвшлийн түүчээ болж чадахуйц бодлогын нам болох,

Гуравдугаарт, Үйл ажиллагааны зарчим, хариуцлага хүлээх чадамжтай болох,

Дөрөвдүгээрт, Гишүүд, дэмжигчдийнхээ төлөөлөл байх чадамж бүхий улс төрийн институци болохын тулд өргөн олны санаа бодлыг уралдуулж, дүрэм журамдаа тусгадаг, түүнийг ягштал мөрддөг соёлыг төлөвшүүлснээр сая амжилттай болно. Шинэчлэл хийхдээ эн тэргүүнд алдаа оноогоо дэнслэх, сургамж, туршлагаа дүгнэх, өнөөгийн сонгуулийн хууль, төрийн албаны хууль, улс төрийн намын тухай хуулиудын хүрээнд, эрх зүйн орчны өөрчлөлтийн хэтийн төлвийг харгалзан байж холыг харах явдал юу юунаас илүү чухал. Үүний сацуу бусад улсын туршлагыг судлах, эх газрын эрх зүйн систем бүхий нээлттэй, ардчилсан засаглалтай, нэгдмэл улс орнуудад улс төрийн намууд хэрхэн хөгжиж, төлөвшсөн түүхээс суралцах учиртай.

Улс орнуудын хөгжлийн замнал харилцан адилгүй боловч коммунист, авторитар дэглэмтэй цөөн орныг эс тооцвол XXI зууны улс төрийн үзэл баримтлалд хэт туйлширсан үзэл санаа, түүнд тулгуурласан нийгэм-эдийн засгийн бодлого үндсэндээ алга болж байна. Хэдийгээр үзэл баримтлалын туйлшрал үгүй болж, эрс ялгаа нь багасч байгаа ч олон ургалч үзлийг хүлээн зөвшөөрөх, түүнийг хамгаалах нь ардчиллын амин сүнс хэвээр байна. Тиймээс ч олон ургалч үзлийг нэгтгэсэн тулхтай улс төрийн хүчин оршин буй эсэх нь өдгөө цагийн ардчилсан засаглалын шалгуур болж байна.

Намын үзэл баримтлалыг тодорхойлохын тулд юуны өмнө нийгэм хэрхэн зохион байгуулагдвал зохилтой вэ гэдэг асуултад хариулж, түүндээ суурилан зорилгоо тодорхойлох хэрэгтэй болдог. Мөн энэхүү зорилгоо хэрхэн гүйцэлдүүлэхээ тодорхойлсон арга замаа томъёолсон байх шаардлагатай болно. Учир нь үүний цаана зорилго нь арга замаа зөвтгөж болох уу гэдэг философийн асуулт бий. Үүнийг бодолцолгүй улс төрийн дэмжлэг үзүүлсэн хэдэн сая хүний амь нас хүч түрсэн нийгмийн инженерчлэлийн хөлд чирэгдэж сүйдсэн нь гашуун түүх байна.

ЯЛАЛТЫН ТӨЛӨӨ ҮЗЭЛ БАРИМТЛАЛАА ОРХИЖ БОЛОХГҮЙ

Өнгөрсөн хорин зургаан жилийн хугацаанд ардчилсан тогтолцоог төлөвшүүлэх их үйлсэд Ардчилсан хүчнүүдийн гүйцэтгэсэн үүрэг асар их. Тэд цаг үеийнхээ дуу хоолой болж, цөөнх байхдаа ч эрх баригчдад нэгийг сануулж, хоёрыг бодуулж ирсэн. Олонх болсон үедээ хөгжил дэвшлийн төлөө давшингуй, зоримог шийдвэрүүд гаргаж, алдаа оноог нь үүрэлцсэн арвин түүхтэй. Татан буугдалгүй үлдэж, өмнөх нийгмийн өвийг тээж ирсэн далан жилийн түүхтэй хэт зүүний, коммунист намтай өрсөлдөж, нийгэм-улс төрийн тогтолцооны өөрчлөлтийн давалгаанд тэсч үлдэхийн тулд Ардчилсан хувьсгалын эхэн үед үүсгэн байгуулагдсан ялгаатай үзэл баримтлал бүхий улс төрийн хүчнүүд, нэгдэн нийлснээр өнөөгийн Ардчилсан намын суурийг тавилцсан билээ. Ардчилсан хүчнүүд Монголын нийгэм хэрхэн зохион байгуулагдвал илүү зохистой талаар хоорондоо ялгаатай үзэл баримтлалтай байсан. Гэвч тэдгээрийг нэгтгэх боломжтой эсэх, боломжтой бол хэрхэн нэгтгэх талаар нухацтай авч үзэлгүйгээр эрх мэдлийн төлөө нэгдэх нь илүү чухал гэж үзсэн нь өнөөгийн өндөрлөгөөс харвал алдаа байжээ гэж дүгнэвэл буруудахгүй болов уу. Ардчилсан хүчнүүд нэгдэн нэг нам болсон нь сайн зүйл мөн. Гэхдээ улс төрийн үзэл баримтлал, үнэт зүйлс, нийгэм-эдийн засгийн хөгжлийн арга замыг хэрхэн тодорхойлж буйгаараа ойртон нэгдэх бус зөвхөн сонгуульд ялахын тулд нэгдсэн. Үүний уршгаар өнөөгийн үзэл баримтлал нь тодорхойгүй, олон фракц бүлэглэл бүхий Ардчилсан намыг буй болсон. Чухам иймээс Ардчилсан намын шинэчлэлийн хүрээнд юун түрүүнд үзэл баримтлалын шинэчлэлийг чухалчлан үзэж өргөн олноо хэлэлцүүлбэл зохино.

ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ШИНЭЧЛЭЛД НЭМЭРЛЭХ САНАА

Ардчилсан намын үзэл баримтлалын шинэчлэлийг Үндсэн хуулийн хүрээнд, нийгэм эдийн засгийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан, олон зууныг дамжин тогтсон үндэсний соёл, зан заншлыг анхааран, ардчилсан замналаар амжилттай хөгжин дэвшиж буй бусад улс орны улс төрийн намуудын сайн туршлагаас суралцан хэрэгжүүлэх учиртай. Намын түүх, гишүүд дэмжигчдийнх нь санаа бодлыг тандсаны үндсэн дээр намын жирийн гишүүний хувьд үзэл баримтлалын шинэчлэлийг нэг өгүүлбэрээр багтаан илэрхийлэх гээд үзье:

Ардчилсан нам эрх чөлөөт, хүчирхэг иргэний нийгэмд суурилсан, эдийн засгийн эрх чөлөөг дэмжигч, эрх чөлөө нь тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн үндэс гэдэгт итгэгч, үндэсний эрх ашиг, уламжлал, соёлыг батжуулан хөгжүүлэгч, шударга ёсыг эрхэмлэгч, баруун төвийн үзэл баримтлал бүхий улс төрийн нам байна.

Одоо харин дээрх нэг өгүүлбэрээ задалж, өөрийн дэвшүүлж тавиад байгаа үзэл баримтлалын шинэчлэлээ дэлгэрүүлэн тайлбарлахыг хичээе.

ХҮЧИРХЭГ ИРГЭНИЙ НИЙГМИЙГ ЦОГЦЛООН ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

- Хувь хүний эрх, эрх чөлөөг дээдлэн, төрийн аливаа үйл ажиллагааг явуулахдаа хуульд зааснаас бусад тохиолдолд хувь хүний эрх чөлөөнд аливаа хэлбэрээр халдахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх
- Төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг чухалчлан, иргэдээ алагчилаагүй шийдвэр гаргадаг байх бөгөөд тэрхүү шийдвэрийг гаргах үйл явц болон хяналт, (хуулиар хязгаарлагдсанаас бусад тохиолдолд) хэрэгжүүлэлтэд иргэдийн оролцоог хангадаг байх
- Төрөөс хараат бус, сайн дураараа эвлэлдэн нэгдсэн иргэдийн ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн институциудийн хууль ёсны ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрч, тэдгээрийн үйл ажиллагааг дэмжих, түүнчлэн дотооддоо бие даасан засаглалыг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх
- Нийгмийн сайн сайхны төлөө өөрийн авьяас чадвар, санхүү, хүч хөдөлмөрөө зарцуулан ажилладаг ашгийн бус байгууллагуудын оршин байхыг хүлээн зөвшөөрч, тэдгээрийн үйл ажиллагааг хөхиүлэн дэмжиж хүнлэг, энэрэнгүй, иргэний нийгмийг цогцлоон хөгжүүлэх
- Иргэн бүр төр, нийгэм дэх тодорхой сонирхлын бүлгээс үл хамааран дуу хоолойгоо илэрхийлэх боломжоор хангагдаж, аливаа үйл явдлыг цензургүйгээр олон нийтэд хүргэж, хуурмаггүй бодит үнэний талд зогсож чаддаг бие даасан, хараат бус сэтгүүл зүйг хөгжүүлэх
- Олон ургалч үзлийг хамгаалах, цөөнхийн эрхийг хүндэтгэн үздэг байхыг нийгэм дэх аливаа институциудад төлөвшүүлэх

ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР:

- Төрийн үндсэн үүргийг өмчийн аливаа хэлбэр, өмчлөх эрхийн баталгааг хангах, иргэдийн сайн дурын үндсэн дээр тохиролцсон гэрээг хүчин төгөлдөр гэж үзэх ба түүнийг хамгаалах, гэрээний хэрэгжилтийг хангах
- Нийгмийн гишүүдийн баялаг хуримтлуулахыг хөхиүлэн дэмжиж, хувийн хэвшил нь баялгийн хуваарилалтыг илүү сайн гүйцэтгэдэг гэдгийг бүрнээ хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ, ашгийн байгууллагуудын өргөжин хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлэх
- Хувь хүн, байгууллага хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулан хуримтлуулсан аливаа орлого, ашгаа чөлөөтэй захиран зарцуулах эрхийг баталгаажуулах
- Бизнесийн үйл ажиллагаан дахь төрийн оролцоог хумьж, нийтийн ашиг сонирхолд нийцэж байгаа тохиолдолд оролцогч талуудын оролцоонд суурилсан төрөөс хараат бус нийгмийн институцийн хүрээнд шийдвэр гаргах боломжийг бүрдүүлэх, төрийн оролцоо зайлшгүй нөхцөлд зохицуулалтын үүрэг гүйцэтгэх түвшинд хязгаарлагдмал хүрээнд оролцох
- Эдийн засгийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжиж, гадаад дотоодын иргэн, аливаа хуулийн этгээд зах зээлийг хянах, өрсөлдөөнийг хязгаарлахын эсрэг тууштай зогсох
- Байгалийн баялгийг хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүйгээр ашиглан Монгол Улсын нийт иргэдэд тэгш хүртээмжтэй байх бодлого баримтлан өнөө үеийн хөгжлийг тэтгэн, хойч үедээ өвлүүлэх үндэсний хуримтлалыг бий болгох гол зорилт тавих. Гэхдээ баялгаас буй болсон санг зарцуулахдаа үндэсний эрх ашиг, олон нийтийн санаа бодол, тогтвортой хэтийн хөгжлийн шаардлагад нийцүүлэхийг эрмэлзэх
- Гадаадын хөрөнгө оруулалтыг эдийн засгийн хөгжлийг тэтгэгч чухал хүчин зүйл гэж үзэн нэг улс орноос хамааралгүй тэнцвэртэй хөрөнгө оруулалтыг урамшуулах, гэхдээ эх үүсвэрийнх нь хувьд гадаадын улс орнуудын төрийн өмч, хууль бус үйл ажиллагаанаас бий болсон хөрөнгийг оруулахгүй байх
- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх засгийн газрын зардлыг 30%-иас хэтрүүлэхгүй, төсвийн алдагдлыг боломжит хамгийн бага түвшинд барьж, засгийн газрын зээлийг хязгаарлах
- Оюуны өмчийг өмчийн бусад хэлбэрийн адил хүлээн зөвшөөрч хууль ёсны эзэмшигчийн өмчлөх эрхийг хамгаалах
- Төв банкны засгийн газраас хараат бус, бие даасан байдлыг баталгаажуулах, түүний үндсэн чиг үүрэгт хөдөлмөр эрхлэлт, үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хадгалах үүргийг багтаах
- Хувийн хэвшил өргөжин хөгжих нөхцөлийг хангасан, нийгмийн хөгжлийг тэтгэж хүрэлцэхүйц оновчтой, ялгаварлалгүй татварын тогтолцоог бүрдүүлэх, татвараас зайлсхийх, нуун дарагдуулахтай тууштай тэмцэх
- Дунд хугацаанд олон тулгуурт эдийн засгийн суурийг бий болгох, урт хугацаанд мэдлэг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэн, уул уурхайн салбараас хамааралгүй эдийн засгийн тогтолцоог бий болгох
- Эдийн засгийн үйл ажиллагааны аливаа салбарт, хувийн хэвшилд татаас олгох явдлыг бууруулах, зайлшгүй татаас олгох тохиолдолд нийтийн эрх ашиг, эдийн засгийн үр ашгийг шалгуур болгон үздэг байх

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

- Эрүүл мэндийн үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд суурилсан санхүүжилтийн механизмыг бүрдүүлэх замаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний салбарт өмчийн хэлбэр харгалзахгүй өрсөлдөх орчныг бүрдүүлэх.
- Суурь боловсролыг үнэ төлбөргүйгээр олгох тогтолцоог бэхжүүлэхийн зэрэгцээ бүх шатны боловсролын чанарыг дээшлүүлэхэд анхаарч тус салбарт хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
- Хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, зохистой хөдөлмөр эрхлэлтийн зарчмыг өмчийн хэлбэр харгалзахгүй мөрдлөг болгох
- Үр дүнтэй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тодорхойлох замаар хөдөлмөрийн орлогыг хувь хүн, айл өрхийн өсч дэвжих баталгаа болгох
- Өтөл насанд амьжиргааны чанарыг бууруулахгүй байх нөхцөлийг бүрдүүлж чадахуйц бие даасан тэтгэврийн даатгалын тогтолцоог хөгжүүлэх
- Хөдөлмөрийн насыг даатгалын тогтолцооны тогтвортой байдлыг алдагдуулахгүй байх түвшинд хүйсээр ялгахгүйгээр, дундаж наслалттай уялдуулан нэмэгдүүлэх
- Нийгмийн халамжийг зөвхөн зорилтот бүлэгт, амьжиргааны баталгаажих түвшинг хангахуйц хэмжээнд хүргэх
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд идэвхтэй оролцоход дэмжлэг үзүүлж, хөдөлмөр эрхлэх боломж, нөхцлөөр хангах

ШУДАРГА ЁСЫГ ТОГТООХ, САЙН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

- Хязгаарлагдмал оролцоо бүхий засаглах чадавхтай төрийн цомхон бүтцийг бий болгох, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн бие даасан хараат бус байдлыг хамгаалах
- Төрийн институциудын үйл ажиллагааны уялдааг сайжруулах замаар үйл ажиллагааны давхцал, хийдлийг багасгах, хөрөнгө санхүү, хүний нөөцийг үр ашигтай зарцуулах
- Улсын их хуралд үйл ажиллагаагаа тайлагнадаг байгууллагуудын засгийн газар, улс төрийн аливаа үйл ажиллагаанаас ангид ажиллах нөхцөлийг бүрдүүлэх
- Шүүхийн бие даасан хараат бус ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, шүүхийн үйл ажиллагаанд иргэний нийгмийн хяналт тавих боломжийг нэмэгдүүлэх
- Зайлшгүй шаардлагатайгаас бусад лиценз олгох, стандарт мөрдүүлэх, хяналт тавих Засгийн газрын чиг үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлэх
- Чадварлаг, өрсөлдөх чадвартай, мэрит зарчимд үндэслэсэн төрийн албыг бий болгох, төрийн албанд улс төрийн нөлөөлөл, оролцоог устгах
- Засгийн газрын бодлого, үйл ажиллагаанд хяналт тавих чадавхийг бие даасан бодлогын судалгааны байгууллагуудын оролцоотойгоор хууль тогтоох байгууллагын түвшинд бэхжүүлэх
- Ардчилсан намын дотоод засаглалыг хөгжүүлэн, улс төрийн хариуцлага хүлээх чадвартай, улс төрийн соёл, ёс зүйг өндөрт өргөж, дүрэм журмаа ягштал биелүүлдэг улс төрийн хүчин болон төлөвшүүлж үүгээрээ нийгмийн аливаа институцийг ардчилсан тогтолцоог бэхжүүлэх их үйлсэд манлайлах

УЛАМЖЛАЛ, ҮНДЭСНИЙ СОЁЛЫГ БАТЖУУЛАН ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

- Монгол хэл, уламжлалт соёлоо хамгаалах, хойч үедээ өвлүүлэхэд анхаарч төрийн бодлогын төвд байлгах
- Монгол хэл дээрх мэдлэгийн санг нэмэгдүүлэх, иргэдийг хос хэлтэн болохыг хөхиүлэн дэмжих
- Үндэсний цөөнхийн уламжлал, соёлыг хамгаалах
- Баримтад суурилсан түүхийн судалгааг нэмэгдүүлж, эх түүхээ бодитоор хойч үедээ таниулах

Ардчилсан намын гишүүд бид хэрэв намаа эх орны хэтийн тогтвортой хөгжлийн суурийг зөв тавилцах ёстой улс төрийн хүчин гэж үзэж буй аваас намынхаа үзэл баримтлал, үнэт ба эрхэмлэх зүйлсийг дотооддоо хэлэлцэн тогтож, өргөн олноо ухуулан таниулах учиртай. Чингэж чадваас улс төрийн намын хараа алс, дотооддоо эвдрэлцэх зүйлгүй гар, хөл, сэтгэл нийлж, хойшид бодлого, үнэт зүйлсээрээ бусад намуудаас ялгарч чадах бөгөөд ард түмэн ч ойлгон хүндэтгэж, итгэл үзүүлэх нь дамжиггүй. Та бүхний өргөнөөр хэлэлцэх асуудалд өөрийн санааг нэмэрлэж буйг минь үүгээр хүлээн авна уу.

Доктор Доржпаламын Батчулуун

Аяллын хөтөч

Агуу Петрагийн эх нутаг Йордан

ВВМ©

Петрагийн эх түүхийг ойлгохын тулд бараг хоёр өдөр энд өнжих хэрэг гарна

З.Цэлмэг
@tselmegZGM

Ойрх дорнодын хамгийн тайван газрын нэг Йорданы Хашемын хаант улс нь археологийн дурсгалт газраар нэн баялаг. Газар нутгийн хэмжээгээрээ дэлхийд 112 дугаарт ордог ч археологи болон жуулчлалын 100 мянга орчим дурсгалт газартай. Эдгээр газрыг үзэх л гэж жилд бараг найман сая хүн Йорданы халуун элсэн цөлийг зорьдог. Жуулчдын дийлэнх нь Европ, Арабаас ирдэг байна.

Йорданы археологийн дурсгалт газруудын ихэнх нь Христ болон исламын шашны эртний түүх, зан үйлтэй холбоотой. Тиймээс ч сүсэгтнүүд эндхийг ариун дагшин газар хэмээн үзэж, заавал очих газруудын жагсаалтдаа оруулдаг аж. Йордан голын зүүн эрэгт ариун дагшин гэгдэх Аль-Махтаст хэмээх газар бий. Библид гардагаар Есүс Христийг энд адислаж байсан түүхтэй. Византын эзэнт гүрний үеэс сүсэглэж ирсэн энэ газрыг хожим Дэлхийн соёлын өвд бүртгэсэн байна.

Йордан 1970-аад оноос бүс нутгийн эмчилгээний аялал жуулчлалын төв болжээ. Йорданы хувийн эмнэлгүүдийн нийгэмлэгийн тооцоогоор 2010 онд 102 улсаас 250 мянган эмчлүүлэгч ирж, нэг тэрбум гаруй ам.долларын эмчилгээ хийлгэсэн байна. Дэлхийн банкны тооцоогоор тус улс эмчилгээний жуулчлалаар бүс нутагтаа тэргүүлж, дэлхийн хэмжээнд тавдугаарт бичигддэг аж. Орчин үеийн анагаах ухаанаас гадна Хаммаматын халуун рашаан, Сөнөсөн тэнгист түшиглэсэн уламжлалт эмчилгээгээрээ иргэний дайны хөлд үрэгдэж байгаа олон мянган хүнд хүрч үйлчилдэг байна. 2010 онд аялал жуулчлалаас 4.4 тэрбум ам.долларын орлого тус улсын сан хөмрөгт орсон байна. Гэхдээ “Арабын хавар”-ын уршгаар сүүлийн таван жилд Йорданд жуулчлагчдын тоо 70 хувь буурсан гэх таагүй мэдээлэл бий.

Хэдийгээр исламын шашинтнууд зонхилдог ч баруунаар хэв маягийг хамгийн их шингээсэн гэгддэг Йордан хөрш зэргэлдээ арван улсынхаа иргэдэд визгүй зорчих боломж олгосон. Бусад орны иргэдийн хувьд хоёр, гурав болон зургаан сарын виз олгоно. Визийн төлбөр хугацаанаас хамаарч 40-120 Йорданы динар (JoD) байдаг. Нэг динар 1.41 ам.доллартай тэнцдэг. Улаанбаатараас нийслэл Амман хот руу “Turkish Airlines” шууд нислэг үйлддэг юм. Зардал нь хоёр талдаа 2500 орчим ам.доллар. Мөн хөрш зэргэлдээ орнуудаас такси, автобус, дарвуулт онгоцоор Йорданд зорчих боломжтой.

ӨРТӨГ

Жуулчдын хувьд Йорданд өнгөрүүлэх нэг өдрийн амьжиргааны зардал нь 15 динар орчим. Өөрөөр хэлбэл, ийм хэмжээний мөнгөөр зочид буудал, угаалгын үйлчилгээнээс гадна өдөр бүр фалафель иднэ гэсэн үг. Фалафель гэдэг нь олон төрлийн шошийг нунталган шарж болгосон, арабын ертөнцийн уламжлалт хоол юм. Харин илүү тохилог, үндэсн хоол нь багтсан буудлын үйлчилгээнээс авахыг хүсвэл 10 динар нэмж төлөхөд хангалттай. Зарим буудлын үнэд шар айраг ч багтсан байдаг.

Зочид буудлаас гадуур 1-2 динарын үнэтэй фалафель болон шоштой бургер түгээмэл байдаг байна. Гэхдээ үндэсний хоол идэхийг хүсвэл зочид буудлаас ресторан арай дээр сонголт байх болно. Мөн европ хоолны амт чанар, үйлчилгээгээр таван одтой, тансаг буудлуудыг гүйцэх газар байдаггүй аж. Харин согтууруулах ундаа сонголт ихтэй ч харьцангуй өндөр үнэтэй.

Петра, Амман зэрэг томоохон хотод 4-5 одтой зочид буудлууд арай илүү үнэтэй. Гэхдээ гадны жуулчид ихэвчлэн 2-3 одтой буудлуудад байрладаг. Харин нэг сарааc дээш хугацаагаар амьдрах шаардлагатай бол сарын 200-600 динарын үнэтэй орон сууц түрээслэх нь дээр гэдгийг санахад илүүдэхгүй. [ЗГМ]

» Йордан 1970-аад оноос бүс нутгийн эмчилгээний аялал жуулчлалын төв болж эхэлжээ.

» Европ хоолны амт чанар, үйлчилгээгээр таван одтой, тансаг буудлуудыг гүйцэх газар үгүй.

» Археологи болон жуулчлалын 100 мянга орчим дурсгалт газартай

ЙОРДАНД ЗААВАЛ ҮЗЭХ ГАЗРУУД

ПЕТРА ХОТЫН ТУУРЬ

2000 гаруй жилийн настай Петра хотын туурь бол Дэлхийн долоон гайхамшгийн нэг. МЭӨ 600-аад онд ид мандаж байсан Набатейн хаанчлалын үед асгадыг нүхэлж барьсан энэ аварга туурийг “Сарнайн улаан хот” хэмээн нэрийдэх бөгөөд 1985 онд ЮНЕСКО-гийн Дэлхийн соёлын өвд бүртгэн авчээ. Инженерүүд өнөө хэр нь 12 давхар байшин шиг өндөр энэ байгууламжийн архитектурын нууцыг бүрэн тайлаагүй байна.

Улаан болон Сөнөсөн тэнгисийн хооронд үргэлжлэх цөлийн худалдааны төв байсан Петра хотын туурийг хэд хэдэн байгууламж бүрдүүлдэг. Хоёр км орчим үргэлжлэх хавцал дундуур явж, эртний хаадын эрдэнэсийн сүрлэг гэгч агуйд хүрдэг байна. Үүнээс цааш хаад, язгууртнуудын олон зуун булш байрлуулсан томоохон танхим үргэлжилнэ.

Харин булшны эсрэг талд Ромын эзэнт гүрний үед барьж дуусгасан 7000 хүний суудалтай задгай театр бий. Театрт одоо ч гэсэн урлагийн олон арга хэмжээ болдог.

Эртний Петрагийн туурийн хамгийн том байгууламж нь хадан сүм. Манай тооллын I зууны үед барьсан энэхүү сүмийн 800 гаруй шатаар нэг цагийн турш мацдаг байна.

Петрагийн агуу түүхийг ойлгохын тулд камер эсвэл аппаратаа сайтар цэнэглэж аваад бараг хоёр өдөр өнжихөөс аргагүй гэдгийг туршлагатай аялагчид зөвлөв. Нэг удаагийн оролт нь 50 динар, харин Египет, Израйлиас явж үзэхээр бол 90 динар төлдөг байна. Үүнд буцах унааны хөлс ч багтсан. Мөн даваа, лхагва, пүрэв гарагт 17 динараар шөнийн Петраг үзүүлдэг аж.

Жилд 1.5 сая жуулчин зорьдог Петрад явганаар эсвэл морь, илжиг, тэмээ хөлслөн ордог. Эрдэнэсийн агуйд зорчих морин үйлчилгээ нь үнэгүй. Гэхдээ баттай эсэхийг нь урьдчилж асуухгүй бол гар цайлгах мөнгө гэж 18 динар нэхдэг гэдгийг мэдээд авахад илүүдэхгүй биз ээ.

ВАДИ РАМ

Петратай адил элсэн чулуун бас нэг гайхамшиг нь Йорданы зүүн өмнөд хэсэгт орших Вади Рам тосгон юм. 720 ам метр талбайг хамран орших Вади рам гайхамшигт элсэн хадат уул, өвөрмөц тогтоц бүхий гүүр, улаан элсэн манхан, рашаан ундаргаараа олон жуулчныг татдаг. Дэд бүтэцгүй, уугуул нутгийнхны аж байдал нь жуулчдын нүдэнд ил байдаг Вади рамд нэвтрэхэд таван динар төлнө.

СӨНӨСӨН ТЭНГИС

Манай гарагийн хамгийн нам дор цэг болох Сөнөсөн тэнгис нь дэлхийд хоёрдугаарт орох давслаг гадарга. Тиймээс ч давсны асар их нөөцтэй.

Хэрэв та Амман болон Акаба хотод жуулчилж буй бол Сөнөсөн тэнгисийг аялалынхаа заавал үзэх газруудын жагсаалтад нэмээрэй. Сөнөсөн тэнгис орчмын зочид буудлууд амралтын газрууд тэнгисийн амралтын бүсэд нэвтрэхэд 20 динар төлнө. Харин зочид буудалд буугаагүй бол 40-50 динар төлөх болдог юм. [ЗГМ]

ТРЭНД

Ор хоногийн төлбөрөө ур чадвараараа төлөх боломж

Зочид буудлын болон өглөөний цайныхаа төлбөрийг ур чадвараараа төлөх боломж олгодог Италийн Бартерийн долоо хоног эхлэх гэж байна.

Ирэх сарын 14-20-нд үргэлжлэх тус арга хэмжээнд оролцохыг хүсвэл аялагчид Бартерын долоо хоногийн цахим хуудаст хандаж, ямар ажил хийх ёстойгоо харах боломжтой аж. Жуулчдад зориулсан ажлын жагсаалтад оливи хураах, гар урлал, амьд хөгжмийн тоглолт үзүүлэх, олон нийтийн сүлжээнд мэдээлэл оруулах зэрэг төрөл бүрийн ур чадвар шаардсан үйлчилгээ багтжээ. Мөн зураг авах, цахим хуудасны мэдээлэл оруулах, цонхны хүрээ будах, цэцэрлэгт ажиллах зэргээр ажлын жагсаалт үргэлжилнэ.

Италийн B&B хэмээх аялын захиалгын цахим хуудас 2009 онд анх Бартерын долоо хоногийг зохиож эхэлсэн байна. Тухайн үед цахим хуудаст 1000 хэрэглэгч бүртгүүлж байсан бол энэ жил оролцогчдын тоо одоогоор 2000 давжээ.

Хэрэглэгчдийн 25 хувь нь орон байраа өөр тийшээ аялах эрхээр сольдог бол 19 хувь нь гэр орны, 15 хувь нь маркетинг болон харилцаа холбооны ажилдаа туслуулахыг хүсдэг байна. Харин аялагчдын хувьд 37 хувь нь фото зураг болон видео авах, олон нийтийн сүлжээнд мэдээлэл оруулах, орчуулах зэрэг ур чадвараа ор хоногийн төлбөртөө суутгуулах хүсэлтэй байна. Мөн 14 хувь нь гэр болон ахуйн ажилд туслах, 12 хувь нь нэхмэл, бэлхүүсний бүжиг зэрэг өөрийн авьяасыг санал болгожээ. [ЗГМ]

Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

VACANCY NOTICE

National Project Officer for Animal Health
Green Gold/Animal Health consolidation project (2017-2020)

The Swiss Agency for Development and Cooperation (SDC) in Mongolia seeks to hire a highly motivated professional as a Project Officer for Animal Health for its Green Gold/Animal Health Consolidation project to be implemented during the period January 1, 2017 - December 31, 2020. SDC invites highly motivated and competent professionals to apply for the vacant post.

We offer:
- A position as Project Officer for Animal Health within the project coordination unit, based in UB
- An opportunity to work in a development project in the agriculture sector (sustainable rangeland management, improved marketing of livestock products and better animal health services)
- Good working conditions, attractive compensation package and opportunities for further professional development

What you bring:
- Master or PhD in veterinary sciences or agriculture with knowledge of animal health
- 3-5 years working experience in development projects in similar fields
- Sound knowledge of the veterinary system in Mongolia
- Practical experiences in veterinary and animal health system
- Capacities to deliver technical advice on animal health issues to national partners
- Knowledge of the major animal health issues in Mongolia
- Interpersonal and team working skills and capacities to deliver results on time
- Availability for frequent travels in rural areas
- Excellent written and spoken communication skills in both English and Mongolian

Applications:
Candidates are invited to submit a Curriculum Vitae, including at least 3 recent references and copies of certificates plus a Motivation Letter explaining the interest for the position electronically to following address: ulaanbaatar@eda.admin.ch by mentioning the project and the position no later than 15th of November 2016. Only short-listed candidates will be contacted. No additional information will be provided via telephone or emails.

The Swiss Agency for Development and Cooperation (SDC) is Switzerland's international development and cooperation agency withing the Federal Department of Foreign Affairs.

To find our more information, please refer to our website:

www.eda.admin.ch/mongolia

Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

VACANCY NOTICE

National Project Officer for Sustainable Rangeland Management
Green Gold/Animal Health Consolidation Project (2017-2020)

The Swiss Agency for Development and Cooperation (SDC) in Mongolia seeks to hire a highly motivated professional as a Project Officer for Sustainable Rangeland Management for its Green Gold/Animal Health Consolidation Project to be implemented during the period January 1, 2017 - December 31, 2020. SDC invites highly motivated and competent professionals to apply for the vacant post.

What we offer:
- A position as a Project Officer for Sustainable Rangeland Management within the project coordination unit, based in Ulaanbaatar
- An opportunity to work in a development project in the agriculture sector (sustainable rangeland management, improved marketing of livestock products and better animal health services)
- Good working conditions, attractive compensation package and opportunities for further professional development

What you bring:
- Master or PhD or Bachelor degree in natural resource management, environment, agriculture, economy or related field
- 3-5 years working experience in development projects in similar fields
- Knowledge and practical experiences in sustainable rangeland management
- Experiences in supporting herders organisations (associations, cooperatives)
- Interpersonal and team working skills and capacities to deliver results on time
- Availability for frequent travels in rural areas
- Excellent written and spoken communication skills in both English and Mongolian

Applications:
Candidates are invited to submit a Curriculum Vitae, including at least 3 recent references and copies of certificates plus a Motivation Letter explaining an interest for the position electronically to the following address: ulaanbaatar@eda.admin.ch by mentioning the project and the position no later than 15th of November 2016. Only short-listed candidates will be contacted. No additional information will be provided via telephone or emails.

The Swiss Agency for Development and Cooperation (SDC) is Switzerland's international development and cooperation agency withing the Federal Department of Foreign Affairs.

To find our more information, please refer to our website:

www.eda.admin.ch/mongolia

Лавлах

ОНЦЛОХ ҮЗВЭР

Их хотын их инээд

Хошин шогийн “UB comedy” хамтлаг өнөөдөр 20.00 цагт “Их хотын их инээд” уриатай “Stand up” тоглолтоо хийх гэж байна. Хамтлагийн дөрвөн уран бүтээлч ганцаарчилсан хошин шогийн үзүүлбэр толилуулна. Залуус хошин шогийн энэ төрлийг хөгжүүлэх зорилготой бөгөөд үзүүлбэрээ хөгжилтэй онигоо, цаг үеийн сонирхолтой сэдвээр баяжуулжээ. Энхтайвны гүүрний урд талд байрлах “Stay” лаунжид болох тоглолтын тасалбар 5000 төгрөгийн үнэтэй. “UB comedy” хамтлаг хошин шогийн тоглолтоо долоо хоног бүр тогтмол хийхээр болжээ. [ЗГМ]

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

	X.21	X.22	X.3	X.24	X.25
Өдөр	3°	5°	8°	3°	3°
Шөнө	-6°	-6°	-6°	-4°	-10°
Салхи	6м/с / 7 м/с	6 м/с / 6м/с	8м/с / 6м/с	8 м/с / 7м/с	7м/с / 6м/с
	Үүлшинэ	Багавтар үүлтэй	Үүлшинэ	Бага зэргийн цас орно	Үүлшинэ



ҮЗВЭР

МОНГОЛ БӨХИЙН ӨРГӨӨ
“Намрын хит 2016” нийтийн дууны шилдгүүдийн нэгдсэн тоглолт өнөөдөр болно. Тоглолтод уран бүтээлээрээ олонд танигдсан 20 гаруй дуучин оролцох юм.

МИШЭЭЛ ЭКСПО
Ноос ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа пүрэв гарагт нээлтээ хийлээ. Үзэсгэлэн энэ сарын 24-н хүртэл үргэлжилнэ.

ШАНГРИ-ЛА
“Явуу” брэндийн загварын шоу өнөөдөр 21-нд 19.00 цагаас болно. Тасалбарын үнэ 100 мянган төгрөг.

CROCUS EVENT HALL
“Дижитал” хамтлагийн “Галзуу ганц” тоглолт өнөөдөр болно. Тоглолтод “Ice top”, “Энхтайван”, “Мон Та Реп”, “No name” хамтлагууд, дуучин Gee оролцоно. Тэд тоглолтын орлогоо “Хүн бүр сурах эрхтэй” хөтөлбөрт хандивлах юм. Тасалбарын үнэ 15 мянган төгрөг.

УЛААНБААТАР ЧУУЛГА
“Алтан намар” хөгжмийн тоглолт энэ сарын 27-29-нд болно. Тэмцээнд БНХАУ, ӨМӨЗО, Халимаг, Буриадын хөгжмийн зохиолчид оролцох аж.

ДУУРЬ БҮЖГИЙН ЭРДМИЙН ТЕАТР
“Ulaanbaatar International Jazz series 2016-2017” төслийн хүрээнд АНУ-ын жааз дуучин Кэнни Вашингтон өнөөдөр 19.30 цагт тоглолтоо хийнэ. Тоглолтод Шотландын төгөлдөр хуурч Паул Кэрби, Герман улсын конторбасс хөгжимчин Мартин Зэнкер, БНСУ-ын бөмбөрчин Мин Чан Ким нар оролцоно.

УРАН ЗУРГИЙН ГАЛЕРЕЙ
Хятадын орчин үеийн урлагийн томоохон төлөөлөл болсон 12 зураачийн “Уугуул нутаг” үзэсгэлэн энэ сарын 28-н хүртэл үргэлжилнэ.

ТВ ХӨТӨЛБӨР

	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
08.00	**09.10** “Хуайс мод” уран сайхны кино	**07.00** “Эдийн засгийн түншлэл” тусгай хөтөлбөр	**09.45** “Монголчууд XX зууны эхэнд” нэвтрүүлэг	**09.30** “Тог тог тог” (3 дугаар бүлэг) 9 дүгээр хэсэг
12.00	**11.20** “Сонголт” ахлах ангийнханд зориулав	**12.00** "Бизнесийн хэмнэл" нэвтрүүлэг	**12.15** "Кино миний амьдрал” нэвтрүүлэг	**11.40** "Хар хаймран гутал" хүүхэлдэйн кино 39 дүгээр анги
14.00	**13.30** “Хүрээлэн” амьд ертөнцийн цуврал	**15.00** "Бизнесийн төв цэг" нэвтрүүлэг	**14.05** “Ялалт” шоу нэвтрүүлэг	**15.00** “Өөрчлөлт” 4 дүгээр бүлэг, 14 дүгээр хэсэг
18.00	**18.50** “Үндэсний шилдэг 21” дууны жагсаалт	**17.00** "Bloomberg Surveillance" шууд орчуулгын хөтөлбөр	**18.30** "Score news” мэдээллийн хөтөлбөр	**18.00** “Наашаа цаашаа”
20.00	**20.00** “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөр	**20.30** "Амжилтад хязгаар үгүй” нэвтрүүлэг	**21.30** "Цагаан хадаг” кино бүтсэн түүх	**21.00** "Бидний таван хүүхэд" ОАК 41 дүгээр анги
22.00	**22.10** “Клэйнтон бааз” уран сайхны кино	**22.00** “Студи 1.0” нэвтрүүлэг	**22.00** "Гэрлэн дохио" ОАК 9 дүгээр анги	**23.30** Үдшийн мэдээ

ЗУРХАЙ

Билгийн тооллын 21
Намрын адаг шар нохой сарын нэг цагаан мэнгэтэй улаан хулгана өдөр
Үс засуулбал. Өвчин ирнэ
Наран ургах, шингэх. 07.23-18.02
Барилдлага. Идэр
Шүтэн барилдлага. Хүрэлцэхүй



Аргын тооллын аравдугаар сарын 21, Сугар гараг. Билгийн тооллын 21, Хэрцгий охин одтой, улаан хулгана өдөр.

Өдрийн наран 7 цаг 23 минутад мандан, 18 цаг 02 минутад жаргана. Тухайн өдөр луу, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, үнэт эрдэнийн зүйл авах, угаал үйлдэх, хүүхэд үрчлэн авах, улааны үйл, хур оруулах, дарханы үйлд сайн. Төлөг тавих, морь уралдахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой.

Хол газар явaар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ЭРҮҮЛ МЭНД

Дархлаажуулалтын судалгаа хийнэ

Улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэхийн тулд зургаан сартайгаас 35 хүртэлх насны иргэдийн дунд дархлаажуулалтын судалгаа хийхээр болжээ. Судалгааг ирэх долоо хоногоос ЭМЯ, ДЭМБ хамтран хийх аж.

Өнгөрсөн жил улаанбурхан өвчний улмаас олон нярай амиа алдсан нь судалгаа, бэлтгэл хангалтгүй байсантай холбоотой гэж ЭМЯ-ны Шуурхай удирдлагын нэгжийн захирал Д.Нарангэрэл онцоллоо. Тэрбээр “Халдварт өвчний тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” хурлын үеэр “Улаанбурхан өвчин манайд 20 гаруй удаа дэгдсэн. 2014 онд улаанбурхны тархалтыг зогсоосон гэсэн батламж авсан ч яг жилийн дараа дахин гарсан. Бид юун дээр алдсан бэ гэдгээ эргэн харлаа. Иргэд, эмч нар энэ өвчин бүрэн устсан гэх ойлголттой байснаас дархлаагүй хүний тоо хуримтлагдсан байсан” гэв. Мөн тэрбээр “ХӨСҮТ-ийн ачаалал ихэссэн, тандалтын судалгаанд дүн шинжилгээ хийж чадаагүй, залуу эмч нарын чадвар муу байсан” гэж дүгнэлээ. Тиймээс эрсдлийн менежментийг сайжруулахын тулд 4-5 жил тутамд дархлуужуулалтын судалгааг хийж, түүнд үндэслэн арга хэмжээ авахаар болжээ. [ЗГМ]

ЗГМ: СҮДОКҮ

				9	2			
		7					6	
				5		2	7	
							9	
9	3			6			8	1
		1				5		
6		2						
	8							4
			1		9			5

7	2	1	8	3	4	9	6	5
9	4	5	1	2	6	3	7	8
8	6	3	7	5	9	1	2	4
6	3	8	9	4	1	7	5	2
1	5	7	2	6	3	4	8	9
2	9	4	5	7	8	6	3	1
3	7	2	4	9	5	8	1	6
4	8	6	3	1	2	5	9	7
5	1	9	6	8	7	2	4	3

(Өмнөх дугаарын хариу)

ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР.
1. Эрт өмнө
3. Их Британи болон Умард Ирланд улсын засаглал
4. Сиамын хаант улс гэдэг нэртэй байсан улс
5. Шувууны далавчин дахь жижиг хэсэг
6. Удам
7. Монголын Пентатоник академийн ерөнхийлөгч
9. Эмэгтэй, бүсгүй (хүндэтгэсэн нэр)
11. Хүн, амьтны төрсний дараах анхны сүү
13. Ондоо
16. Иемен улсын нийслэл. Ази, Африкийн зааг дахь буланг эл хотын нэрээр нэрлэсэн
17. Дува сохрын дүү
18. Монголын Хятан (Кидан) улсын дээд өвөг улс
20. Монте Кристо гүн болон хувирсан Эдмон Дантесийн хэлмэгдэн хоригдож асан цайз, шорон

ХӨНДЛӨНГӨӨР:
1. Хөлбөмбөгийн анхны ДАШТ-ийг зохион байгуулан, улмаар аваргын цом хүртсэн улс
4. Хэмжээ
6. Хаалга, орох хэсэг
8. Тэсэрч, дэлбэрэх сумны орц
10. Их хэмжээний тогтмол ус
12. Ойр
14. Шингэн хадгалах шилэн сав
15. Боксын тулааны дэвжээ
16. Цэцэг нуурын хөдөлгөөний удирдагч Аюушийн тодотгосон алдар
18. Язгуур Монголын овог
19. Өвөрхангай аймгийн театр түүний нэрэмжит болсон МУГЖ
21. Авиа
22. Дэмжигч, бишрэгч
23. Дэлхийд цор ганц байх хөшөө байгуулсан ном

Өмнөх дугаарын хариу / 10.18

ЭЛЕКТРОН БАРАА, КОМПЬЮТЕР, ТАВИЛГЫН ТАХ ЗЭЭЛД ТЭРГҮҮЛЭГЧ

“БСБ СЕРВИС” КОМПАНИ 25 НАС ХҮРЛЭЭ

Үүсгэн байгуулагдсаны 25 жилийн ойн баяртаа зориулан электрон бараа, компьютер, гэрийн болон оффис тавилгын төрөлжсөн 9000м2 талбай бүхий Монголын хамгийн том дэлгүүр болох “БСБ Мегамолл” дэлгүүрт Electrolux, Hotpoint, Indesit, Fagor, Zanussi, Candy, Delonghi, Kenwood, Philips, Sony, Panasonic, Toshiba, Apple, Black Red White, KAM зэрэг дэлхийн шилдэг 70 гаруй брэндийг нэгтгэж, БҮХ БАРААГАА 25% хямдруулан, урьд өмнө байгаагүй хамгийн том гэнэтийн бэлгийг худалдан авагчиддаа барилаа.

Монголынхоо мянга мянган өрхийн өнгө төрхийг засалцан, эх орныхоо хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулан бүтээн байгуулагч байж Таны гэр бүлийн хэрэгцээг бүрэн хангасан, тав тухтай, тохилог амьдралыг цогцлоохын төлөө бид шаргуу ажилласаар байна.

Бидний үйл ажиллагааг дэмжин 25 жилийн турш манайхыг сонгон үйлчлүүлсэн нийт хэрэглэгчиддээ талархсанаа илэрхийлье!

БСБ СЕРВИС ХХК-ИЙН ХАМТ ОЛНООС

www.bsb.mn
Better Lifestyle
BSB

Syndicated articles from
FINANCIAL TIMES

© The Financial Times Limited [2015]. All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Санхүүгийн луйврын эсрэг дайтагч

Эльвира Набиуллинаг Оросын төв банкны захирагч болоход хатуухан дүр зураг угтаж байлаа. > 10

Авлигын хэрэг шинэ засаглалд ч халтай

Бразил түүхэнд хамгийн ноцтой хямралаас гарч ядаж буй үед төв банк нь дөрвөн жилд анх удаа бодлогын хүүгээ танав. > 10

Германд эм хямдарсан нь маргаан дэгдээлээ

Европын шүүх Герман улс үнийн хяналт, Европын нэгдсэн зах зээлийн зохицуулалтыг зөрчсөн гэж дүгнэжээ. > 10

Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн аварга өсөлт тус улсын эдийн засгийн хөгжлийг тодорхойлогч болж хувирлаа.

BBM©

Хятадад орон сууцны үнэ хадаж байна

◀1

Учир нь тус хошуунд байгуулсан "Тогосны хот", "Нэгдсэн Вант улсын өргөө", "Прованс хүрээлэн" зэрэг хорооллын орон сууцны нэг ам метрийн үнэ зургаан сарын дотор хоёр дахин буюу 24 мянган юань (3600 ам.доллар) болтлоо суга өссөн. Цагийг нь олсон наймаа хийсэндээ тэрбээр олзуурхаж байлаа.

"Гу-Анийн үнэ жинхэнэ тэнгэрт хадсан юм болсон" хэмээн Пэн овогт өгүүлэв. Бээжинд үл хөдлөх хөрөнгөтэй тэрбээр үнэ унах тооцоонд үндэслэн цаашид орон сууц худалдаж авах наймаагаа түр завсарлажээ. "Эцэстээ тулсан үнэ эргээд хэсэгтээ л бууна. Үнэ унах хүртэл Бээжингээс дахин байр худалдаж авах хэрэг алга" гэж Пэн овогт тайлбарлав.

Хятадын орон сууцны зах зээл "хөөсөрч" байна. Үл хөдлөх хөрөнгийн Savills China компанийн тооцоогоор Бээжин, Шанхай зэрэг том хотод зөвхөн өнгөрсөн жилд байрны үнэ 25-аас дээш хувиар өсчээ. Үнийн өсөлт энэ онд арай жижиг хотуудыг ч хамрах боллоо. Наймдугаар сарын байдлаар зүүн өмнөд эргийн хот Шяменьд байрны үнэ жилийн өмнөхөөс 40 хувиар ссөн байна.

Гэхдээ дээр өгүүлсэн Гу-Ань хошууны орон сууцны үнийн өсөлт онцгой. Бээжингийн хоёр дахь олон улсын нисэх буудлыг тус хошуунаас умардад 40-хөн километрийн зайд, шинэ Дашин дүүрэгт байгуулж байгаа нь үнэ өсөхөд түлхэц болжээ. Нийт 70 тэрбум юанийн өртгөөр байгуулж буй шинэ нисэх буудлыг 2018 онд ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй байгаа юм.

Үл хөдлөх хөрөнгө, дэд бүтцийн салбарт орж буй асар их хөрөнгө оруулалтын ачаар БНХАУ-ын Засгийн газар энэ оны эдийн засгийн зорилтоо амжилттай биелүүлэх төлөвтэй байна. Тус улсын дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ энэ оны гуравдугаар улиралд өнгөрсөн оны мөн үеэс 6.7 хувиар өссөнийг лхагва гарагт Бээжин мэдэгдсэн. Гэвч эдийн засгийн өсөлтийг энэ онд 6.5-7 хувь хүртэл өсгөх зорилт амжилттай биелэх нь тодорхой болсонтой уялдан үнийн хөөрөгдөлд иргэд дургүйцэх нь ихэслээ. Үүссэн шинэ нөхцөлд зохицуулах зорилгоор орон нутгийн захиргаад "хэт халсан" зах зээлийг "хөргөх" арга хэмжээ авч эхлэв.

Аравдугаар сарын эхээр бүтэн долоо хоног үргэлжилдэг баярын амралтаар орон сууцны арилжаанд хязгаарлалт тогтоохоор төлөвлөж байгаагаа орон нутгийн 14 удирдлага мэдэгдсэн. Уг арга хэмжээний хүрээнд орон сууцны зээлийн хэмжээг багасгах, илүү орон сууц худалдаж авахыг хориглохоор заажээ. Энэ удаад тус улсын 22 хотод орон сууцны арилжаанд тавих хяналтыг чангатгахаар төлөвлөж байна. Орон сууц худалдан авахын тулд мөнгө хадгалах хэрэгцээ ихэссэнээс шалтгаалан БНХАУ нь хадгаламжийн хүүгээр дэлхийд өндөр улсын нэгд тооцогддог боллоо.

Пэн овогтын адилаар Бээжингийн банкны ажилтан, 27 настай Стефани Гуо ч тавдугаар сард байр авахаар төлөвлөж байв. Гэвч төлөвлөгөө бүтсэнгүй. Тухайн үед нийслэл хотын тавдугаар тойрог дотор байр авахаар судлахад ам метр нь 50 мянган юань буюу хэт үнэтэй байлаа. Гэтэл эдүгээ ам метр нь 65 мянга буюу бүр ч үнэтэй болов. "Тавдугаар тойрог дотор байрны үнэ тэнгэрт хадчихсан юм бол бүр холын Тунжоу дүүргээс хайя гэж бодлоо. Тэгсэн Тунжоуд ч үнийг нь дийлэхгүй юм билээ" хэмээн Стефани өгүүлэв.

БНХАУ-ын удирдлага орон сууцны арилжаа цэцэглэж буйтай уялдан өр зээл ихсэж байгаад түгших боллоо. Энэ оны хоёрдугаар улирлын байдлаар орон сууцны зээлийн нийт хэмжээ жилийн өмнөх үеэс 30 хувиар өссөнийг БНХАУ-ын төв банкны судалгаа харуулж байна. Энэ онд банкуудаас олгох нийт зээлийн 70 хувь нь барилга угсралтын компани, орон сууц худалдан авагчдад ногдож байгааг Mizuho Securities Asia-гийн эдийн засагч Шень Жяньгуан тайлбарласан юм. Ноён Шень өнөөгийн Хятад орны орон сууцны "хөөсрөл"-ийг 1980-аад оны Японтой зүйрлэв. Тухайн үед Японы барилгын компаниуд "Та хаанаас, хэрхэн зээл авах нь огт сонин биш. Гол нь үнэ өсөж л байвал болно" гэсэн бодолтой байсныг Шень овогт өгүүллээ.

Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн аварга өсөлт тус улсын эдийн засгийн хөгжлийг тодорхойлогч болж хувирч байна. Энэ оны эхний хагасын байдлаар БНХАУ-ын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн 20 хувь нь барилга угсралт, үл хөдлөх хөрөнгийн салбарт ногдож байгааг China International Capital Corporation-ий эдийн засагч Лян Хун ярьсан юм. Тиймээс үнэ өсөлтийн эсрэг Хятадын удирдлага шийдвэртэй арга хэмжээ авч чадахгүй хэмээн зарим нь шүүмжлэв. "Засгийн газар улс орны эдийн засгийн өсөлтөд хор болох юм хийхгүй" хэмээн Gavekal Dragonomics-ийн орон сууцны шинжээч Розалиа Яо үзлээ.

Дээрхийн зэрэгцээ Хятад улсын бүс нутгийн олон янз байдал нэгдмэл арга хэмжээ авахад саад учруулж байна. Тус улсад нэг, хоёрдугаар зэрэглэлийн том хотуудад үнэ өсөж, эрэлт нь нийлүүлэлтээсээ түрүүлж байхад, хөдөөгийн бүс нутгуудад байдал эсрэг байгаа юм.

FT

ХБНГУ цөмийн хаягдлын зардлаа шийдвэрлэж чадлаа

Ги Шазан

ХБНГУ-ын Засгийн газар мянга мянган тонн цөмийн хаягдлыг хадгалахад зарцуулах олон тэрбум ам.долларын зардлыг хуваарилах хууль танилцууллаа. 2011 онд болсон Фүкүшимагийн ослын дараахан Берлин цөмийн цахилгаан станцуудаа 2022 он гэхэд бүрэн зогсоохоор шийдвэрлэсэн. Цөмийн станцуудыг зогсоох, цэвэрлэгээ хийхэд шаардлагатай 48 тэрбум еврогийн зардлыг хэрхэн гаргуулах нь тус улсад тулгамдсан асуудал болоод байсан юм.

ХБНГУ-д атомын цахилгаан станц ажиллуулдаг E.ON, RWE, Vattenfall, EnBW компаниуд лхагва гарагт танилцуулсан хуулийн дагуу цөмийн реакторуудаа зогсоож, задлан буулгах үүрэг хүлээнэ. Харин цахилгаан станцуудын цөмийн хаягдлыг хадгалах зардлыг төр хариуцна. Гэхдээ уг зардлыг цахилгаан станц ажиллуулдаг компаниуд хамтран байгуулах тусгай сангаас гаргах юм. Цөмийн эрчим хүчний компаниудаас нийт 17.4 тэрбум еврогийн хөрөнгө татаж, төрийн мэдлийн сан байгуулахаар төлөвлөж байна.

Сан байгуулах ажил бэрхшээлтэй. Засгийн газар дээрх зардлын 35.5 хувьтай тэнцэх "Эрсдэлийн төлбөр"-ийг мөн л эрчим хүчний компаниудаас татах бодолтой байна. Уг төлбөрийг төлсөн тохиолдолд компаниуд цөмийн хаягдал хадгалах бүхий л үүргээс чөлөөлөгдөх юм. Эцсийн дүндээ цөмийн эрчим хүчний компаниуд 23.6 тэрбум евро төлөх ёстой болж таарч байна.

ХБНГУ-ын эрчим хүчний компаниуд, татвар төлөгчдийн аль алинд хэт дарамт учруулахгүйгээр шийдвэрлэсэн дээрх тооцоог энэ оны дөрөвдүгээр сард мэргэжлийн 19 хүний бүрэлдэхүүнтэй тусгай комисс гаргажээ. Дулааны, цөмийн эрчим хүчнээс сэргээгдэх эрчим хүчинд шилжих шилжилт тус улсын цахилгаан эрчим хүчний компаниудад цохилт болж байна. Байгалийн хий, нүүрс шатааж гаргадаг эрчим хүчний зах зээлийг төрийн татаастай салхи, нарны эрчим хүчний зах зээл улам бүр шахсаар.

ХБНГУ-ын уламжлалт дулааны цахилгаан станцуудын орлого их хэмжээгээр багаслаа. Өнгөрсөн онд E.ON-ийн зардал түүхэндээ үнэмлэхүй хэтэрсэн бол RWE ашиг ч хуваарилаагүй өнгөрсөн. Санхүүгийн хүнд нөхцөлд байгаа дээрх хоёр компани бүтцийн шинэчлэл хийж, ашигтай салбараа тусад нь бие даалгах замаар оршин тогтнохоор чармайж эхэллээ. E.ON компани есдүгээр сард цахилгаан станцуудаа Франкфуртэд бүртгэлтэй Uniper хэмээх шинэ охин компани болгон бие даалгасан. RWE энэ сарын эхээр "Ногоон" эрчим хүчний салбар, цахилгаан хуваарилах сүлжээгээ тусад нь Innogy компани болгон салгав.

Засгийн газраас боловсруулсан цөмийн хаягдал хадгалах санаачилга "Эдийн засгийн хүчин чадалд нь ахадсан ачаа болох" талаар дээрх хоёр компани бүр дөрөвдүгээр сард гомдол тавьсан юм. Шинээр байгуулах тусгай санд оруулах шаардлагатай нэмэлт хоёр тэрбум еврог хөрөнгө оруулалт татах замаар олохоос өөр аргагүйг E.ON тавдугаар сард тайлбарласан.

Гэхдээ тус компани лхагва гарагт Засгийн газраас танилцуулсан хуулийг хавьгүй нааштай гэж үнэлэв. "Олон арван жил шийдэж чадахгүй маргалдсаар ирсэн түвэгтэй асуудлыг нэг мөр болгох боломж бүрдлээ" хэмээн тус компани мэдэгдэж байна. Европын комиссын шаардлагад нийцүүлэн гаргаж буй шинэ хуулийг удахгүй Бундестагаар хэлэлцүүлэх ёстой. Шинэ хуулийг энэ оны эцсээр баталж амжина хэмээн ХБНГУ-ын Засгийн газар найдаж байна.

FT

Лондоны "боссууд" ажилчдыг удирдах зөвлөлд оруулах саналыг дэмжив

Патрик Женкинс

Компаниудын удирдлагын зөвлөлд ажилтан, ажилчдыг оруулах Ерөнхий сайдын санаачилгыг дэмжиж буй Ситигийн (тайлбар: Лондон хотын санхүүгийн төв хэсэг) дээд тушаалтнууд дотор Legal & General (L&G), Aberdeen Asset Management зэрэг том компанийн захирлууд багтлаа. Ажилтан, ажилчин захирал үүсгэх нь "Хэрэгтэй санаачилга" хэмээн Aberdeen-ий Ерөнхий захирал Мартин Гильберт тайлбарлав. Ажиллагсдын төлөөлөгчийг удирдлагад багтаах нь "Зүйтэй арга хэмжээ" L&G-ийн тэргүүн Найжел Уилсон үзэж байна.

Банкны эзэн, үл хөдлөх хөрөнгийн менежер, технологийн тэргүүлэх компанийн захирал зэрэг Ситигийн нэр нөлөө бүхий хүмүүсээс бүрддэг FT City Network онлайн форумаас явуулсан санал асуулгад Их Британийн 60 гаруй компанийн удирдлага болон бодлого тодорхойлогчид оролцлоо. Санал асуулгад оролцогсдын дийлэнх нь компанийн удирдлагын зөвлөлд ажилтан, ажилчдыг оруулах нь зүйтэй хэмээн хариулсан юм. Уг хариулт нь Ерөнхий сайд Тереза Мэйгийн санаачилгад дургүйцэж байсан нийт бизнесийн салбарынхны хувьд санаанд оромгүй зүйл болов.

Засгийн газрыг тэргүүлэх хугацаандаа капитализмд шинэчлэл өрнүүлэх зорилготой Ерөнхий сайд компанийн удирдлагын цалин, тэтгэвэр төдийгүй удирдлагын арга хэлбэрийг ч өөрчлөхийг эрмэлзэж байна. Хатагтай Тереза Мэйн санаачилгыг Их Британийн хөрөнгө оруулалтын тэргүүлэх хоёр групп болох L&G, Aberdeen дэмжиж байгаа нь ихээхэн ач холбогдолтой. Учир нь компани дэмжих тохиолдолд дийлэнх хөрөнгө оруулагчид ч ижил байр суурь баримтална.

Ерөнхий сайдын шинэ бодлогыг хөрөнгө оруулагчдын нүдээр харах тохиолдолд "Үнэ цэнэтэй санаа" болохоор байгааг UBS-ийн ерөнхий захирал Сержио Эрмотти тайлбарлав. "Ажиллагсад маань компанийн хоёр дахь гол хөрөнгө оруулагч болж таарах нь. Хэрэв ажиллагсад хувьцаагаа нэг байгууллагаар дамжуулан нэгтгэж чадвал удирдлагын зөвлөлд жинтэй санал гаргагч болж хувирна" хэмээн тэрбээр өгүүллээ.

Ажиллагсдыг удирдлагын зөвлөлд хамруулах нь ажил хэрэгч, үр дүнтэй шийдэл гэдгийг гадаадад ажилласан туршлагаараа үзэж туулсан форумын гишүүд дотор санхүүгийн Nationwide компанийн захирал Дэвид Робертс багтаж байна. "Анхандаа ч бараан талаас нь төсөөлдөг байлаа. Гэтэл өөрийн биеэр үзэж өнгөрүүлэх хэрээр нааштай үнэлэх болсон" хэмээн Австрийн Bawag банкинд арваад жилийн өмнө ажиллаж байсан туршлагатай ноён Робертс ярьсан юм.

Ерөнхий сайдын шинэ бодлогыг эрс эсэргүүцэгчдийн нэг нь Land Securities-ийн тэргүүн Дэйм Элисон Кэрнуот. Хэрэв хатагтай Мэй "Өргөн цар хүрээтэй, аварга бизнесийн салбарт хариуцлагагүй ажиллагааг зогсоохын тулд" ийм арга хэмжээ авч байгаа бол "Эцсийн үр дүн одоогийнхоос онц өөрчлөгдөхгүй" хэмээн тайлбарлав.

FT

Syndicated articles from

FINANCIAL TIMES

© The Financial Times Limited [2015]. All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Санхүүгийн луйврын эсрэг дайтагч

Макс Седдон, Лионел Барбер

Эльвира Набиуллинаг Оросын төв банкны захирагч болоход хатуухан дүр зураг угтаж байлаа. 150 орчим банк сэжигтэй гүйлгээ хийхэд оролцдог нь бүртгэгджээ. Харин өнөөдөр Оросын санхүүгийн харанхуй булан, нүх сүвийг цэвэрлэснээр дээрх тоо хавьгүй цөөрч 10 хүрэхгүй үлдсэн гэж хатагтай Набиуллина ярьж байна.

Гэхдээ энэ бол зөвхөн эхлэл гэнэ. Тэрбээр "Хуулийг үл хүндэтгэдэг хүмүүст зайлшгүй шийтгэл оногдоно гэдгийг ард иргэд ойлгож байгааг харахад сэтгэл таатай байна" гэв. Оросын төв банкны захирагч Financial Times сонины сурвалжлагчид өгсөн ярилцлагадаа луйварчдын эсрэг авч буй ноён Путины арга хэмжээг өндөр үнэлсэн юм.

Хатагтай Набиуллина Их театрын зэргэлдээ орших неоклассик загварын оффистоо сурвалжлагчийг хүлээн аваад "Журам мөрддөггүй банкныхныг шийтгэж, заримыг нь шоронд илгээж байгаа. Ийм зүйл дахин гаргахгүй байх нь чухал" хэмээв. Зөөлөн дуугаар хүүрнэх 52 настай энэ эмэгтэйг санхүүгийн луйврын эсрэг дайтагч гэж хэлэхээргүй. Тэрбээр албан тушаалдаа орсноос хойш 276 банкийг хааж, 28-д нь засан сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлжээ.

Францын яруу найргаас чээжээр эш татах дуртай, татар гаралтай хатагтай Набиуллина 2013 онд Ерөнхийлөгч Путины зарлигаар төв банкны захирагч болохоосоо өмнө эдийн засгийн сайдаар ажиллаж байв. Удалгүй Орос улс нефтийн үнийн уналт ба Украйнаас шалтгаалсан өрнөдийн хоригоос үүсэн хямралтай нүүр тулав. Хатагтайд хуучинсаг хатуу бодлогоосоо татгалзахыг шаардсан дарамт шахалт ирсэн байна. Дэлхийн томоохон төв банкууд өсөлтийг дэмжихийн тулд уламжлалт бус арга хэмжээ рүү хандсан бол Набиуллина инфляцийг хазаарлах хатуу бодлогоо үргэлжлүүлсэн юм.

Оросын төв банкны захирагч Эльвира Набиуллина

BBM©

Одоо олон шинжээч Оросын эдийн засгийг ангал руу унахаас аварсан гэж түүнийг үнэлдэг. Оросын өндөр албан тушаалтны хэлснээр "Тэр бол Путины хамгийн их итгэдэг эдийн засагч" юм. Хатуу зохицуулалт, бодлогын өндөр хүүгийн талаар банкныхны шүүмжлэлтэй тулгарах үед хатагтай Набиуллина татварын сахилгын хөдөлшгүй байр сууриа даруу зан, яст мэлхийн хуягаар урласан хүрээтэй нүдний шилнийхээ цаана нууж байв. Тэрбээр "Банкны систем ашигтай ажиллаж эхэллээ. 2014 оны сүүлчээр эхэлсэн хямралын өмнөх түвшиндээ хүрч байна. Гэхдээ зарим асуудлыг нүд анин өнгөрүүлснээр бус, хяналтаа чангатгаснаар хийж чадсан" хэмээн өгүүллээ.

Набиуллина энэ сард төв банкинд халаа сэлгээ хийсэн. Харин үүнийгээ бэлэн мөнгөний хямрал үүсэх төлөвтэй байгаа үед банкуудыг будлиан хутгахаас сэргийлж, асуудлыг илрүүлэх шаардлагаас үүдсэн гэж тайлбарлав. 1998 оны Оросын уналтаас хойш хамгийн хүнд эдийн засгийн хямралын цагт түүний бодлого гайхалтай үр дүн харуулсныг тэмдэглэх хэрэгтэй. Путины засаглалын эхний хугацаанд Оросын түргэн өсөлтийн гол сурвалж байсан нефтийн үнэ Набиуллинаг төв банкны захирагч болсноос нэг жилийн дараа огцом унасан юм. Үүний улмаас 2014 оны арванхоёрдугаар сард мөнгөний хямрал үүсч, банкуудад хүндээр туссан билээ.

Банкууд долоо хоног зогсох дээрээ тулж, төв банк нөөцөөсөө 12 тэрбум ам.доллар зарцуулсан авч рублийн ханшийг барьж чадсангүй. Рубль түүхэн доод хэмжээндээ хүрэх үед Набиуллина хэдхэн өдрийн дотор хоёр удаагийн цочир арга хэмжээ авав.

Эхлээд бодлогын хүүг 17.5 хувиар тогтоосон бөгөөд улмаар төлөвлөснөөс сар шахмын өмнө рублийг хөвөх ханшинд шилжүүлсэн юм. Харин одоо түүний эдгээр арга хэмжээг Оросын эдийн засагт дэмжлэг болсон гэж нийтээр хүлээн зөвшөөрч байгаа аж. Үр дүнд нь газрын тос, байгалийн хийгээс тал нь бүрддэг Оросын төсвийн орлого тасрах аюулаас сэргийлж, одоогийн байдлаар төсвийн алдагдал харьцангуй бага буюу гурван хувьтай байна.

Набиуллина "Бид зах зээлийн сэтгэл зүйн хүлээлтийг тайвшуулахын тулд нөөцөөсөө зарцуулсан. Улмаар нефтийн үнийн уналт урт хугацаанд үргэлжлэхийг ойлгосон тул чөлөөтэй хөвөх ханш руу шилжсэн" хэмээн өгүүлэв. Тэрбээр санхүүгийн шуургыг туулах явцад хямралын менежментийн талаар чухал сургамж авснаа онцлоод "Хамгийн гол нь догматик бус, уян хатан, тууштай байх ёстой. Хямралын үеэр асар их шүүмжлэл, дарамт ирсэн. Гэхдээ модыг ой гэж харж болохгүй" хэмээжээ.

Ирэх жилийн эцсээр инфляцийг дөрвөн хувь болгон бууруулах Набиуллинагийн зорилтот бодлогыг Путин дэмжсэн явдлыг Москвагийн олон шинжээч хачирхалтай гэж үздэг. Бодлогын хүү харьцангүй зөөлөрч, 10 орчим хувьтай байгаа. Харин инфляци хоёр жилийн хугацаанд 17 хувиас буурч, хэдийнэ 6.4-т хүрлээ. Төв банкны захирагч хэлэхдээ мөнгөний бодлогодоо ард иргэдийн итгэлийг олж авах зорилго тавьснаа онцлов.

Тэрбээр "Бид дуртайдаа бодлогын хүүгээ өндөр бариад байгаа юм биш. Харин инфляцийг бууруулах шийдвэр төгс байгаад гол учир нь бий. Доогуур инфляци Оросын эдийн засагт ашигтай. Гэхдээ хүн бүрийг үүнд итгүүлж чадаагүй л байна" гэжээ.

Бодлогын хүү бага байх нь Оросын эдийн засгийг түргэн босгож, өсөлтийг нэмэгдүүлнэ гэдэг үзэл санааг хатагтай Набиуллина няцаасан. Улмаар эдийн засгийн хүнд нөхцөлд түүний явуулж буй хатуу бодлого хангалттай бус байж болох ч амьдрах чадвартай гэж ярьсан юм. Оросын төв банкны захирагч цааш нь "Хуучин цагт эдийн засгийг өсгөдөг байсан хүчин зүйлүүд өөрчлөгдсөн. Мөнгөний бодлогоос үл хамааран бүтээмжийг дээшлүүлэхэд тусалж чадах бүтцийн өөрчлөлт шаардлагатай байна" хэмээн зорилгоо тодорхойлжээ.

FT

Авлигын хэрэг шинэ засаглалд ч халтай

Саманта Пирсон

Бразил түүхэнд хамгийн ноцтой хямралаас гарч ядаж буй үед төв банк нь дөрвөн жилд анх удаа бодлогын хүүгээ таналаа. Мөнгөний бодлогын хороо Селикийн бенчмаркийг үндсэн 25 үзүүлэлтээр 0.25 хувь хасаж, 14 болгожээ. Олонх шинжээч 2012 оноос хойш анх удаа бодлогоо зөөлрүүлэх арга хэмжээ авна гэж хүлээж байсан авч хэмжээний талаар санал зөрж байв. Шинжээчдийн зарим нь 50 үзүүлэлтээр бууруулсан хүчтэй алхам хийх байх гэж таамаглаж байсан юм. Өнгөрсөн онд эдийн засаг агшиж, инфляци өссөний улмаас Бразилын төв банк хүүгээ барихаас өөр аргагүйд хүрсэн. Гэвч сүүлийн саруудад үнийн дарамт зөөлөрч, зах зээлийн чиглэлтэй шинэ Засгийн газарт итгэх итгэл сэргэсэн тул хүүг танах боломж бүрджээ.

Лхагва гарагт гарсан энэхүү мэдэгдэлтэй хамт төв банк хүнсний үнэ буурсныг мэдээлэв. Гэхдээ хөрөнгө оруулагчдын итгэлийг алдахгүйн тулд цаашдаа хүү бууруулах шийдвэрийг инфляцийн нааштай дүн, Засгийн газрын татварын бодлогын амжилттай уялдуулна гэжээ. Бразилын Ерөнхийлөгч Мишел Темер ирэх жилүүдэд төсвийн зардлыг бодитойгоор царцаах бодлогын хүрээнд иргэдийн дургүйцлийг үл харгалзан тэтгэврийн санд шинэчлэл хийхээр амлав.

Goldman Sachs-ын эдийн засагч Алберто Рамос "Төв банк урагшлах хөтөлбөртөө өөрчлөлт оруулсан нь зөөлөн бодлогыг өргөн хүрээнд хэрэгжүүлэх байх гэсэн хүлээлт рүү хүйтэн ус цацсан хэрэг боллоо" хэмээн дүгнэсэн байна. Түүхий эдийн уналтын дараа өсөлтийг дэмжихийн тулд мөнгөний бодлогыг өргөтгөх байх гэсэн хүлээлт бүс нутгийн орнуудад үүсээд байгаа. Аргентин зээлийн хүүгээ идэвхтэй бууруулж эхэлсэн бол Чили, Колумбад ийм бодлого хэрэгжүүлэх шахалт үүсээд байна.

Гэвч Бразилын өмнө тулгарч буй улс төрийн эрсдэл хавьгүй илүү юм. Төв банк шийдвэрээ зарлахаас хэдхэн цагийн өмнө цагдаагийнхан Бразилын парламентын доод танхимын дарга асан Эдуардо Кунаг баривчилсан. Энэ нь Темерийн тэтгэврийн бодлогод эргэлзээ төрүүлж эхлэв. Мөрдөн байцаагчид түүнийг Petrobras хэмээх улсын компаниас хахууль авсан хэрэгт буруутгасан юм. Харин Куан өөрөө үүнийг няцаажээ.

Ерөнхийлөгч асан Дилма Русеффэд үл итгэх асуудлыг зохион байгуулсан ноён Куна шинэ Засгийн газрын гишүүдийн хэргийг илчилсэн ял зөөлрүүлэх гэрээ хийвэл конгрессоор шинэчлэлийг дэмжүүлэхэд бэрхшээл учирна гэж шинжээчид үзэж байгаа аж. Eurasia Group зөвлөх фирмийн шинжээч Кристофер Гарман "Ноён Кунаг баривчилсан явдал нь Темерийн хувьд ч Petrobras-ийн хэрэг гол эрсдэл болохыг сануулахаас гадна улс төрийн тавцанд ноцтой нөлөөлж болзошгүй"гэсэн юм.

FT

Германд эм хямдарсан нь маргаан дэгдээлээ

BBM©

Стефан Вагстил

Европын шүүх Герман үнийн хяналт Европын нэгдсэн зах зээлийн зохицуулалтыг зөрчсөн гэж дүгнэсний дараа тус улсын иргэд хямд эм худалдан авах боломжтой болж байна.

Шүүхийн шийдвэр гарснаар гадаадын онлайн захиалга авдаг компаниуд дотоодын эм нийлүүлэгчидтэй жороор олгодог эмийн зах зээлд үнээр өрсөлдөх юм. Энэхүү арга хэмжээг Германы хэрэглэгчдийг төлөөлдөг Паркинсон өвчний холбоо талархан хүлээн авав. Түүнчлэн Германы хэрэглэгчдийн нийгэмлэг уг шийдвэрийг дэмжин хэрэглэгчдэд мөнгөө хэмнэх үүд хаалга нээгдлээ гэжээ.

Харин Германы эмзүйчдийн холбоо дургүйцсэн мэдэгдэл гаргаж, "Эрүүл мэндийн асуудалд зах зээлийн хязгааргүй хүчин зүйл хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах бодлогоос дээгүүр тавигдах ёсгүй" хэмээсэн байна. Германы Эрүүл мэндийн яам дээрх шийдвэрийг хянан үзэхээ мэдэгдэв. Тус яам эм үйлдвэрлэгчдийн ашиг сонирхлыг бодолцож, орон нутгийн эмийн сангуудаар эм түгээх үйлчилгээг дээд түвшинд зохион байгуулах ёстой гэсэн юм.

Европын шүүх Засгийн газрын зохицуулалтаар жортой эмийг түгээх нь Европын чөлөөт худалдааг зөрчсөн хэрэг гээд эмийн хяналтыг дэмжсэн Германы шүүхийн шийдвэрийг няцаав. Европын шүүхийн шийдвэр хил дамнасан худалдаанд хамаатай. Түүнчлэн тус тус руу эм оруулж байгаа гадаадын компаниудад тавьсан хориг саадыг чөлөөлж байгаа тул дотоодын нийлүүлэгчдэд хамаарахгүй аж. Германы эрүүл мэндийн албан журмын даатгалаас эмийн үнийн зарим хэсгийг нөхөн олгодог учир хямд эм хайхад түлхэц болдог байна.

Гадаадаас онлайнаар эм нийлүүлэгч компаниуд Германы үнийн доод хэмжээнд урамшуулал олгодог байв. Гэвч эм үйлдвэрлэгчдийн лобби 2014 онд шүүхэд гомдол гаргаж, уг хөнгөлөлтийг зогсоосон билээ.

Голландад төвтэй DocMorris и-мэйлээр захиалга авдаг компанийн захирал Макс Мюллер манай сонинд ярихдаа Европын шүүхийн шийдвэр гарангуут тус компанийн вэб сайт руу хандалт 40 хувь нэмэгдсэнийг мэдээллээ. Тэрбээр "Хэрэглэгчид журам өөрчлөгдсөний үр ашгийг хүртэх болно" гэжээ.

Гэвч Германы 20 мянга орчим эмийн сангуудыг нэгтгэдэг Эмзүйчдийн холбоо шүүхийн шийдвэр дотоодын улстөрчдийг сөрсөн хэрэг боллоо хэмээжээ. Тиймээс цаашид үүнтэй тэмцэх аж. Германд эмийн бөөний болон жижиглэн худалдааг зохицуулдаг нарийн түвэгтэй журмаар дотоодын эмийн сангуудын эрх ашгийг хамгаалдаг. Гэвч Европын шүүх тогтмол үнийн бодлогыг дэмжээгүй агаад өрсөлдөөн ихэссэнээр шинэ эмийн сангууд бий болно гэж үзсэн байна.

Германы эмийн зах зээл жилдээ 50 тэрбум еврогийн эргэлттэй бөгөөд хүн ам насжихын хэрээр хэрэглээ нь жилдээ таван хувиар өсөж байгаа. Үүнээс жороор олгодог эм 38 тэрбумыг эзэлж, бусад нь шууд худалддаг эм байгаа юм. 2003 онд гадаадын компаниуд зарга үүсгэж, Германы шууд олгодог нь эм сүлжээнд нэвтэрч чадсан бөгөөд одоо зах зээлийн 16 хувийг эзэлжээ. Ноён Мюллер хэлэхдээ жортой эмийн хувьд гаднынхан одоо гурван хувьтай байгаа бол интернэт худалдааны ачаар маш түргэн өсөх боломжтой гэж найдаж байна гэв.

FT

Эдийн засаг

ХӨДӨӨ АЖ АХУЙ

Нөөцийн махгүй хавар

Ирэх онд бид нөөцийн махгүй хаваржих нь

Г.Байгал
@baigalZGM

Намар... Халгиж, цалгисан элбэг, дэлбэг үе. Тиймээс монголчууд намрыг баян, баялаг хэмээн дууддаг биз. Жил жилийн намар далай шиг арвин ургацтай биднийг угтдаг. Энэ намар ч тийм байна. Хүнсний ногооны гарц арвин. Мах, сүү элбэг дэлбэг. Үнэ нь өөд хөөрчихөөгүй, нам түвшинд хэлбэлзэж байна. Угаас намар бол үнэ уруудаг улирал л даа.

Махны үнийн доод хязгаарыг нийслэлд тогтоодог "Хүчит шонхор" худалдааны төвд хонины мах 4000-5000, үхрийх 5500-6000 төгрөгийн ханштай байна. Энэ үнэ ирэх сарын эцэс хүртэл хадгалагдах эсвэл уруудах төлөвтэй. Ийм магадлалыг махны худалдаачид дэвшүүлж байна. Учир нь идэш бэлтгэх цаг дөхсөн тул нийлүүлэлт нэмэгдэх хүлээлттэй. Зах зээлийн хуулиар энэ нь үнэ буурах үндсэн нөхцөл болдог. Яг энэ үед нөөцийн махны талаар яривал хэр олон хүн сонирхох бол? Намартаа налайсаар нөөцийн махыг мартдаг. Гэтэл уг нь өдийд бэлтгэсэн махаараа бид өвөл, хаврыг давдаг.

Манай зах зээлд хавар болгон махны үнэ өсдөг гажиг бий. Нийлүүлэлтийн хомсдолоос шалтгаалж, үнэ өсдөг гажигийг төр мах нөөцөлж саармагжуулдаг байв. Хүн амд үйлдвэрийн аргаар бэлтгэсэн, хямд мах нийлүүлсний төлөө хувийн хэвшлийн үйл ажиллагааны зардлыг Засгийн газар даана. Нэмээд урамшуулал олгоно. Иим зарчмаар махны үнийг өсгөлгүй барьж ирсэн. Энэ хавар л гэхэд өнгөрсөн жилүүдийн нөөцийн махны урамшуулал болох 14.5 тэрбум төгрөгийг олгож, 4.5 тэрбум төгрөгийг векселээр санхүүжүүлсэн. Ингэснээр төр, хувийн хэвшлийн тооцоо дуусcан. Үүнтэй зэрэгцээд төр махны үнэ тогтоох төлөвлөгөөнөөсөө нэрээ татсан юм. Төсөв, мөнгөний хүрэлцээ муу гэсэн шалтгаанаар нөөцийн мах бэлтгэхээ больж, хувийн хэвшилд энэ ажлыг үлдээв.

> **Үйлдвэрүүд уг нь өдийд бэлтгэлээ базаах учиртай. Гэвч нөөцийн махны сураг алга**

Төр оролцохоо больсон эхний жил буюу энэ хавар нөөцийн мах бэлтгэсэн үйлдвэр тун цөөн байлаа. Өнгөрсөн тавдугаар сард "Баатрууд тэнгэр" компани бага хэмжээний мах худалдсаныг эс тооцвол үндсэндээ бараг борлуулалт байсангүй. Худалдааны төв, хүнсний дэлгүүрүүдэд махны үнэ 10000 төгрөгийг давчихаад байхад "Баатрууд тэнгэр" үйлдвэрийн аргаар бэлтгэсэн нөөцийн махаа бараг 50 хувиар хямд худалдаж байв. Энэ нь мэдээж махны үнийн өсөлтийг хазаарлаагүй. Гэхдээ нийслэлчүүдэд хямд мах худалдан авах сонголт олгосон.

С.Батсайхан / ЗГМ©

Харин ирэх онд бид нөөцийн махгүй хаваржих нь. Үйлдвэрүүд уг нь өдийд бэлтгэлээ базаах учиртай. Гэвч нөөцийн махны сураг алга. Мах нөөцөлж буй аж ахуйн нэгж ховор байгааг Монголын махны холбоонoос мэдээлсэн. Өнгөрсөн жилүүдэд нөөцийн мах бэлтгэсэн хэд хэдэн аж ахуйн нэгж рүү утас цохилоо. Багахан хэмжээтэйг бэлтгэхээр зэхэж байгаа гэснээс өөр хариу хэлсэнгүй. Шалтгаан нь хөрөнгө, санхүүгийн байдал. Санхүүжилт муугаас мах бэлтгэл саатаж байгаа ажээ. Багахан хэмжээгээр бэлтгэх махаа дотоодод бус хилийн чанадад экспортлох сонирхолтойгоо үйлдвэрүүд илэрхийлэв. Ингээд бодохоор дотоодод тодруулбал бидэнд нөөцийн мах хүртэхгүй нь боллоотой. Багаар бодоход жилд дунджаар 7000-8000 тонн нөөцийн мах бэлтгэж байж, хаврыг давдаг жишиг бий. Хэрэв ирэх хавар махны үнэ дэвшилбэл ханшийг хэрхэн тогтоон барих вэ? Энэ асуултыг салбарын яаманд тавьтал төсөв, мөнгөний хүрэлцээ гэснээс өөр тайлбар хэлсэнгүй.

Нөөцийн махнаас болж уртаас урт дараалал үүсдгийг бид мэднэ. Дээрээс нь махны зах зээл ченжийн тогтолцоотой. Ченжүүд махны зах зээлийн өнгө төрхийг тодорхойлдог. Энэ тогтолцоо махны үнийг хөөрөгддөг гэмтэй. Гэтэл хавар нийлүүлэлт татарч, махны үнэ дээш шийдэгдэхэд түүнийг саармагжуулах, хавхавч алга байх нь. Нэгэнт нь ченжийн тогтолцоог халж, ганц дамжлагатай үйлдвэр барьж чадаагүй энэ үед махны үнийн хөөрөгдлөөс сэргийлэхийн тулд нөөц бүрдүүлэхээс өөр гарцгүй болохыг өнгөрсөн түүхүүд харуулж буй билээ. [ЗГМ]

БАЙР СУУРЬ

Төв банк уян хатан ханшаар валютын нөөцөө хамгаалдаг

Б.Баяртогтох
@bayartogtokh

Монголбанкны Зах зээлийн газрын захирал Б.Батдаваатай ярилцлаа. Тэрбээр "Нэгдсэн платформоор болчихоор зах зээлд оролцогчид ямар ханшаар хэдий хэмжээний валютыг худалдах болон худалдан авах эрэлтийн мэдээллийг шууркай харах боломжтой болно" гэв.

-Монголбанк төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах Үндсэн чиглэлийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн. Төслийн гуравдугаар заалтад "Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, институцийг бэхжүүлэх" зорилт тусгагдсан. Энэ хүрээнд Төв банк ирэх онд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр зорьж байна вэ?

-УИХ-ын тогтоолын төслийн 3.1-д валютын дотоодын захын дэд бүтцийг хөгжүүлж, ил тод, үр ашигтай байдлыг хангасан шинэ тогтолцоог бүрдүүлэх гэсэн заалт бий. Монгол Улсын валютын захыг харвал "Найман шарга" буюу бэлэн валютын зах, арилжааны банкуудаар ихэнх арилжаа дамждаг. Гэтэл бусад улсын жишээг харвал банк хоорондын зах голлох үүргийг гүйцэтгэдэг бөгөөд арилжаа нь дэвшилтэт программ хангамжаар дамжин явагддаг. Тодруулбал, арилжааны ханш болон холбогдох мэдээлэл нь оролцогсдод ил тод, нээлттэй, тухайн ханшаар арилжаа чөлөөтэй хийгддэг.

Гэтэл манайд "Найман шарга" зах дээр очоод 100 мянган ам.доллар шууд зарья гэвэл авах хүн олдохгүй. Банк ороод нэг сая ам.доллар авья гэвэл "Манайх зарахгүй" гэх тохиолдол ч сүүлийн саруудад гарсан. Өөрөөр хэлбэл, валютын зах маань хөрвөх чадвар муу. Захад ямар ханшаар хэлцэл хийгдэж буй нь мэдэгдэхгүй байгаа. Үүнээс шалтгаалаад ямар нөхцөл байдал үүсдэг вэ гэхээр тухайлбал экспортын орлоготой компаниуд орлогоо ам.доллар эсвэл юаниар олдог шүү дээ. Орж ирсэн гадаад валютаа эргүүлээд төгрөг болгоё гэхээр ямар ханшаар хэнд зарах нь ойлгомжгүй болчихдог. Ингээд тухайн компани өөрийнхөө харьцдаг хоёр, гурван банкны дунд дуудлага худалдаа зохион байгуулаад, эсвэл хэн илүү өндөр үнэ санал болгосонд нь валютаа зардаг. Ингээд тухайн валютыг худалдаж авсан банк нь өөрийнхөө томоохон харилцагч, импортлогч компаниудад тухайн валютыг зарах нөхцөл байдал үүсдэг байх жишээтэй.

-Ягаад ийм нөхцөл байдал үүсчихээд байна вэ?

-Ягаад гэвэл манай улсад өнөөдөр валют арилжааны нэгдсэн платформ байхгүй, үүнээс шалтгаалан зах зээлд мэдээллийн зөрүүтэй байдал бий болдог.

Харин Монголбанк долоо хоног бүрийн мягмар, пүрэв гарагт арилжааны банкуудын дунд валютын дуудлага худалдаа зохион байгуулдаг. Энэ нь валютын зах дээр эрэлт, нийлүүлэлт нь ямар байна вэ, бодит ханш хэд дээр тогтож байна вэ гэдгийг мэдэх зорилготой. 2009 онд бид дуудлага худалдааг анх эхлүүлэхдээ "Түр зуурын хэрэгсэл" гэж үзэж байсан. Өөрөөр хэлбэл, жилийн дараа бид банк хоорондын валют арилжааны нэгдсэн платформтой болно гэж төлөвлөж байсан юм. Гэсэн хэдий ч Монголбанкны гадаад валютын дуудлага худалдаа нь өнөөг хүртэл валютын захын эрэлт, нийлүүлэлтийн мэдээллийг түгээх гол хэрэгсэл хэвээр байна.

-Тэгвэл 2017 онд энэ чиглэлээр тодорхой ахиц, дэвшил гарна гэж хүлээж болох уу?

-Бидний зүгээс төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэлдээ валютын захын дэд бүтцийг хөгжүүлэх талаар тусгасан бөгөөд энэ тухай судалгаа шинжилгээний ажил хийж эхэлсэн. Тухайлбал, энэ нь аль болох зах зээлд оролцогсдынхоо тоог нэмэгдүүлж, мэдээллийн зөрүүгүй болгоё гэж зорьж байна. Өнөөгийн нөхцөлд мэдээлэл сайтай, томоохон харилцагчид нь хоорондоо хэлцэл хийчихдэг. Энэ дунд зарим харилцагч нь хаягдах нөхцөл байдал үүсдэг. Нэгдсэн платформтой болчихоор зах зээлд оролцогчид ямар ханшаар хэдий хэмжээний валютыг худалдах болон худалдан авах эрэлтийн мэдээллийг шууркай харах боломжтой болно.

Нэг ёсондоо мэдээлэл ил тод, хөрвөх чадвар өндөртэй валютын захтай бий болох юм. Ингэснээр мэдээллийн тэгш байдал хангагдаж, зах зээл дээр өрсөлдөөнт орчин үүснэ. Тэр хэрээр зах зээлд оролцогчид нэмэгдэж, валютын ханшийн тухай хүлээлт ч харилцан адилгүй байх нөхцөл бүрдэнэ гэсэн үг. ▶12

ЗГМ ТОВЧХОН

» ДУУДЛАГА ХУДАЛДАА

40

Сая юань. Монголбанк гадаад валютын дуудлага худалдаагаар арилжааны банкуудад 345.06 төгрөгийн ханшаар 40 сая юань нийлүүллээ.

» УУЛ УУРХАЙ

9.5

Хувь. Монгол Улсын нийт газар нутгийн 9.5 хувь нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй.

» БАНК САНХҮҮ

12.4

Их наяд. Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон нийт зээлийн үлдэгдэл 12.4 их наяд төгрөгтэй тэнцлээ. Ингэснээр өнгөрсөн оны мөн үеийнхээс 470.3 тэрбум төгрөг буюу 3.9 хувиар өсчээ.

» ҮНЭТ ЦААС

60

Тэрбум төгрөг. Нэг сая төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 12 долоо хоногтой, 60 тэрбум төгрөгийн засгийн газрын үнэт цаасыг арилжлаа.

» ХӨРШ

9.21

Тэрбум ам.доллар. БНХАУ-ыг чиглэх гадаадын шууд хөрөнгө оруулалт есдүгээр сард 1.2 хувиар өссөн байна. Ингэснээр 9.21 тэрбум ам.доллартай тэнцжээ.

» "BB+"

Олон улсын үнэлгээний S&P агентлаг ОХУ-ын "Rosneft" зээлжих зэрэглэлийг "BB+" болгож, төлвийг тогтвортой болгов.

5

Сая тонн. ОХУ-ын Беларусь улсад энэ улиралд нийт таван сая тонн газрын тос нийлүүлэхээр болсон байна.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ доллар	2319.29
Евро	2554.70
Япон иен	22.31
ОХУ рубль	36.86
БНХАУ юань	344.15
БНСУ вон	2.06

Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

VACANCY NOTICE

National Project Officer for Rangelands & Monitoring and Evaluation
Green Gold/Animal Health Consolidation Project (2017-2020)

The Swiss Agency for Development and Cooperation (SDC) in Mongolia seeks to hire a highly motivated professional as a Project Officer - Rangelands (60%) & Monitoring and Evaluation (40%) for its Green Gold/Animal Health Consolidation Project to be implemented during the period January 1, 2017 - December 31, 2020. SDC invites highly motivated and competent professionals to apply for the vacant post.

What we offer:
- A position as Project Officer - Rangeland (60%) and Monitoring and Evaluation (40%) within the project coordination unit in Ulaanbaatar
- An opportunity to work in a development project in the agriculture sector (sustainable rangeland management, improved marketing of livestock products and better animal health services)
- Good working conditions, attractive compensation package and opportunities for further professional development

What you bring:
- Master or PhD or Bachelor degree in natural resource management, environment, social sciences, economy or related field
- 3-5 years working experience in development projects in similar fields
- Practical experiences in monitoring and evaluation and in rangeland management
- Knowledge in gender equality mainstreaming
- Interpersonal and team working skills and capacities to deliver results on time
- Availability for frequent travels in rural areas
- Excellent written and spoken communication skills in both English and Mongolian

Applications:
Candidates are invited to submit a Curriculum Vitae, including at least 3 recent references and copies of certificates plus a Motivation Letter explaining an interest for the position electronically to the following address: ulaanbaatar@eda.admin.ch by mentioning the project and the position no later than 15th of November 2016. Only short-listed candidates will be contacted. No additional information will be provided via telephone or emails.

The Swiss Agency for Development and Cooperation (SDC) is Switzerland's international development and cooperation agency withing the Federal Department of Foreign Affairs.

To find our more information, please refer to our website:

www.eda.admin.ch/mongolia

Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

VACANCY NOTICE

National Project Officer for Marketing
Green Gold/Animal Health Consolidation Project (2017-2020)

The Swiss Agency for Development and Cooperation (SDC) in Mongolia seeks to hire a highly motivated professional as a Project Officer for Marketing for its Green Gold/Animal Health Consolidation Project to be implemented during the period January 1, 2017 - December 31, 2020. SDC invites highly motivated and competent professionals to apply for the vacant post.

What we offer:
- A position as a Project Officer for Marketing within the project coordination unit, based in Ulaanbaatar
- An opportunity to work in a development project in the agriculture sector (sustainable rangeland management, improved marketing of livestock products and better animal health services)
- Good working conditions, attractive compensation package and opportunities for further professional development

What you bring:
- Master or PhD in economy, marketing or agriculture
- 3-5 years working experience in development projects or in private sector
- Knowledge and practical experiences in market system approaches
- Experiences in supporting cooperatives by providing technical business advices
- Proven facilitation and marketing skills
- Good understanding of the agricultural sector (processing and trading)
- Interpersonal and team working skills and capacities to deliver results on time
- Availability for frequent travels in rural areas
- Excellent written and spoken communication skills in both English and Mongolian

Applications:
Candidates are invited to submit a Curriculum Vitae, including at least 3 recent references and copies of certificates plus a Motivation Letter explaining an interest for the position electronically to the following address: ulaanbaatar@eda.admin.ch by mentioning the project and the position no later than 15th of November 2016. Only short-listed candidates will be contacted. No additional information will be provided via telephone or emails.

The Swiss Agency for Development and Cooperation (SDC) is Switzerland's international development and cooperation agency withing the Federal Department of Foreign Affairs.

To find our more information, please refer to our website:

www.eda.admin.ch/mongolia

Эдийн засаг

БАЙР СУУРЬ

Төв банк уян хатан ханшаар валютын нөөцөө хамгаалдаг

Импортын дөрвөн сар орчмын хэрэгцээг хангах нөөцтэй байна

◀11

Энэ нь цаашлаад санхүүгийн үүсмэл хэрэгслүүд хөгжих таатай нөхцөлийг бүрдүүлэх боломжтой. Үүсмэл хэрэгслийн зах зээл хөгжихийн хэрээр зах зээлд оролцогчид ханшийн эрсдэлээ удирдах боломж улам нэмэгдэх юм.

-Монголбанк төгрөгийн гадаад валюттай харилцах уян хатан ханшийн бодлого баримталдаг. Мөнгөний бодлогод байнга тусгадаг. Ер нь ханш яагаад уян хатан тогтох ёстой вэ гэдгийг та тайлбарлана уу?

-Нэгдүгээрт, эдийн засагт үүссэн гадаад болон дотоод шокийг уян хатан ханшаар шингээдэг нь уг дэглэмийн хамгийн гол давуу тал байдаг. Жишээлбэл, манай экспортын орлого 2012 оноос хойш огцом буурсан. Тэр үеэс хойш бид тогтмол ханш барьсан бол манай импорт буурахгүй байлаа. Нөөцөөсөө валют нийлүүлээд л явах нөхцөл байдал бүрдэх байсан. Монголбанк валютын ханш, эдийн засгийнхаа суурь нөхцөлтэй нийцтэйгээр суларч, уян хатан тогтохыг хүлээн зөвшөөрснөөр гадаад валютын орох, гарах урсгалаар дамжуулаад эдийн засагт тохиргоо хийх боломжийг олгосон. Энэ нь эргээд валютын нөөцөд учрах дарамтыг бууруулна. Сүүлийн үед Монгол Улсын гадаад валютын нөөц нэлээд буурсан, хүндрэлтэй нөхцөл байдал үүсээд байна. Энэ тохиолдолд уян хатан ханшаар дамжуулж валютын нөөцөө хамгаалж үлдэх бололцоотой юм.

-Гадаад валютын өнөөгийн нөөц яг хэдий хэмжээнд байна вэ. Цаашид нөөцөө нэмэгдүүлэхийн тулд ямар арга хэмжээ авах вэ?

-2016 оны наймдугаар сарын байдлаар гадаад валютын албан нөөц 1.141.9 сая ам.доллартай тэнцэж байна. Олон улсын жишгээр гадаад валютын нөөц тухайн улсын гурван сарын импортын хэрэгцээг хангах түвшинд байвал нөөц хангалттай гэж үздэг. Бид өнөөдрийн байдлаар дөрвөн сар орчмын импортын хэрэгцээг хангах нөөцтэй байна. Гэхдээ өмнөх жилүүдийнх шиг их хэмжээний интервенц хийж, ханш барих оролдлого хийх орон зай бага болчихлоо. Тийм учраас экспортын орлого буурсан, гадаад валютын орох урсгал багассан ийм үед ханшийн уян хатан бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хэрэгтэй болж байгаа. Түүнчлэн эдийн засгийнхаа суурийг бэхжүүлэх, импортын хэт тэлэлтийг тодорхой хэмжээнд хязгаарлах, валютын орох урсгалыг дэмжих, валютын нөөцөө хамгаалах зорилгоор мөнгөний бодлогын хүүгээ өсгөөд байна. Цаашдаа Засгийн газраас валютын орох урсгалаа нэмэгдүүлж чадвал Монголбанк нөөцөө нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

Бидний зүгээс төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэлдээ валютын захын дэд бүтцийг хөгжүүлэх талаар зорилт тусгасан.

ЗГМ©

» Манай улсад одоогоор валют арилжааны нэгдсэн платформ байхгүй, үүнээс шалтгаалан зах зээлд мэдээллийн зөрүүтэй байдал бий болдог.

» Монголбанкны гадаад валютын дуудлага худалдаа нь өнөөг хүртэл валютын захын эрэлт, нийлүүлэлтийн мэдээллийг түгээх гол хэрэгсэл хэвээр байна.

» Үүсмэл хэрэгслийн зах зээл хөгжихийн хэрээр зах зээлд оролцогчид ханшийн эрсдэлээ удирдах боломж улам нэмэгдэх юм.

-Монголбанк мөнгөний бодлогын хүүг өсгөсөн нь нэг талаас ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах, төгрөгт итгэх итгэлийг сэргээх зорилготой байсан. Гэтэл гадаад валютын нөөцөө хамгаалах зорилго ч бас байсан юм байна?

-Наймдугаар сарын 18-нд бодлогын хүүг өсгөсөн. Ингээд ес, аравдугаар сард хийсэн интервенцийн хэмжээг харвал сард дунджаар хоёр сая ам.доллар байгаа. Энэ сард л гэхэд Монголбанк зах дээрээс найман сая ам.доллар худалдаж аваад байна. Үүнээс өмнөх саруудад Төв банкны интервенцийн хэмжээ сард дунджаар 140 сая ам.долларт хүрдэг байсан. Тэгэхээр бодлогын хүүгээ нэмэгдүүлж, ханш уян хатан тогтворжих бололцоог бүрдүүлснээр валютын нөөцөө хамгаалж, цаашлаад нөөцөө нэмэгдүүлэх боломжтой болж байгаа юм.

-Гадаад валютын нөөц хангалттай, эсвэл бага байх нь эдийн засагт ямар байдлаар нөлөөллөө үзүүлдэг юм бол?

-Ер нь яагаад валютын нөөцийн хэмжээ чухал вэ гэдэг асуудал бий. Өнгөрсөн наймдугаар сарын 19, наймдугаар сарын 26-ны өдөр манай зээлжих зэрэглэлийг S&P болон Moody's агентлагаас дараалан бууруулсан. Үүний гол шалтгаан нэгдүгээрт, Монгол Улсын гадаад төлбөр түргэн гүйцэтгэх чадвар буюу гадаад зээл, өрөө төлөх чадвар нь муудчихлаа, гадаад валютын эх үүсвэр нь бага боллоо гэж байгаа юм. Энэ нь үндсэндээ манай нөөцийн хэмжээг л хэлээд байгаа юм. Мөн экспортын орлого нь хэд болсон, хөрөнгө оруулалт нь сэргэж байгаа эсэх үзүүлэлтийг харж байгаа. Тэгэхээр нөөц багасчихаар эргээд манай зээлжих зэрэглэл буурна. Зээлжих зэрэглэл буурахаар Монгол Улсад орж ирэх зээл, бондын хүү нэмэгддэг. Нөөц буурах тусам Монгол Улс руу орж ирэх зээл, хөрөнгө оруулалтын зардал нэмэгдэх сөрөг талтай. Зээлжих зэрэглэл муутай оронд гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ ч бас хумигддаг. Тэгэхээр нөөцийн хэмжээ буурах нь нийт эдийн засагт гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын итгэх итгэлийг бууруулах сөрөг нөлөөтэй. Тийм учраас валютын нөөцөө ямар нэгэн байдлаар хамгаалах, нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлдэг. [ЗГМ]

Хөрөнгийн биржийн индекс 0.38 хувиар өсчээ



MSE ALL

Монголын хөрөнгийн биржийн пүрэв гарагийн үнэт цаасны арилжаагаар нэг болон хоёрдугаар ангилалд бүртгэлтэй 12 хувьцаат компанийн нийт 11,297 ширхэг хувьцаа арилжжээ. Энэ өдөр Хөрөнгийн биржийн индекс 819.37 нэгж болж 0.38 хувиар өсөв. Ингэснээр зах зээлийн үнэлгээ 1.4 их наяд төгрөгт хүрчээ. Хөрөнгийн биржийн арилжаа сэргэсэн хэвээр байна. Үнэт цаасны үнэлгээ нь тухайн улсын үнэт цаасны зах зээлийн хөгжлийг харуулдаг үзүүлэлт юм.

Монголын үнэт цаасны зах зээлийн үнэлгээ нь хөрөнгийн биржид бүртгэлтэй компани тус бүрийн зах зээлийн үнэлгээний нийлбэртэй тэнцүү. Хэдийгээр эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал хүндхэн байгаа ч дотоодын үнэт цаасны зах зээлд эерэг хүлээлт давамгайлах болов. Энэ нь зах зээлийн өдөр тутмын арилжаанд нөлөөлж байгаа аж. [ЗГМ]

[ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ]
ТАНАЙ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ ЭНД БАЙРЛАЖ БОЛНО
99903584, 99903581

МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАДААД КОМПАНИУД

НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	50.96	▲ +0.43%	10/20/2016
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.025	▼ -10.71%	10/20/2016
PETRO MATAD	MATD	LON	GBX	2.95	▼ -5.6%	10/20/2016
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.04	▲ +2.5%	10/20/2016
GUILDFORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	10/20/2016
PROPHECY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	3.15	▲ +1.59%	10/20/2016
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	3.97	▼ -0.25%	10/20/2016
SOUTHGOBI RESOURCES	SGQ	TSX	CAD	0.35	▲ +16.67%	10/20/2016
XANADU MINES	XAM	ASX	AUD	0.185	▼ -2.63%	10/20/2016
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.3	▼ -6.25%	10/20/2016

ТҮҮХИЙ ЭД

НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ ($)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1269.05	▼ -0.04%	10/20/2016
ЦАГААН АЛТ	PLA	унци	945.9	▲ +0.25%	10/20/2016
МӨНГӨ	SIA	унци	17.675	▲ +0.07%	10/20/2016
ЗЭС (COMEX)	HGA	фунт	210.35	▲ +0.02%	10/20/2016
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	56.46	▲ +0.14%	10/20/2016
WTI ТОС	CLA	баррель	51.27	▼ -0.64%	10/20/2016
БРЕНТ	COA	баррель	52.42	▼ -0.47%	10/20/2016
БЕНЗИН	XBA		150.81	▼ -0.36%	10/20/2016
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	3.188	▲ +0.57%	10/20/2016
НҮҮРС (NYMEX)	QZA	тонн	40	▼ -1.23%	10/20/2016
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	94.5	▼ -3.57%	10/20/2016
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	0.229	▼ -0.3%	10/20/2016
БУДАА	RRA	центнер	10.35	▼ -0.53%	10/20/2016
БУУДАЙ	WA	бушель	422	▲ +0.42%	10/20/2016
КАКАО	CCA	тонн	2641	▲ +0.42%	10/20/2016
КОФЕ	KCA	фунт	1.578	▼ -0.57%	10/20/2016

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
I АНГИЛАЛД 3 КОМПАНИЙН НИЙТ 5,771 ШИРХЭГ ХУВЬЦАА 2,824,877 ТӨГРӨГӨӨР АРИЛЖИГДСАН БАЙНА.				
АПУ ХК	APU	418.77	▼ -1.28 %	10/20/2016
ГОВЬ ХК	GOV	8700	▲ 1.52 %	10/20/2016
СҮҮ ХК	SUU	137	▲ 0.20 %	10/20/2016
II АНГИЛАЛД 9 КОМПАНИЙН НИЙТ 5,526 ШИРХЭГ ХУВЬЦАА 5,826,836 ТӨГРӨГӨӨР АРИЛЖИГДСАН БАЙНА.				
АДУУГ ЧУЛУУ ХК	ADL	1706	▼ -2.46 %	10/20/2016
БАГАНУУР ХК	BAN	2292	▼ -0.48 %	10/20/2016
ЖЕНКО ТУР БЮРО ХК	JTB	68.65	▼ -1.62 %	10/20/2016
МОНГОЛ ШУУДАН ХК	MNP	277	▼ -0.36 %	10/20/2016
РЕМИКОН ХК	RMC	50.1	▲ 0.08 %	10/20/2016
ШАРЫН ГОЛ ХК	SHG	2830	▲ 14.99 %	10/20/2016
ШИВЭЭ ОВОО ХК	SHV	3076	▲ 0.85 %	10/20/2016
ТАВАН ТОЛГОЙ ХК	TTL	2094	▲ 5.54 %	10/20/2016
УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК	UID	510.87	▼ -3.19 %	10/20/2016

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
NASDAQ COMPOSITE	CCMP	5246.41	+2.57	▲ +0.05%	10/20/2016
DAX INDEX	DAX	10660.25	+14.57	▲ +0.14%	10/20/2016
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	14840.49	+88.24	▲ +0.6%	10/20/2016
S&P/ASX 200	AS51	5442.145	+6.78	▲ +0.12%	10/20/2016
S&P 500	INX	2144.29	+4.69	▲ +0.22%	10/20/2016
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3082.204	-2.52	▼ -0.08%	10/20/2016
DOW JONES INDUSTRIAL AVERAGE	INDU	18202.62	+40.68	▲ +0.22%	10/20/2016
TOP 20	MSETOP	11383.9	+67.19	▲ +0.59%	10/20/2016
FTSE 100	UKX	7021.92	+21.86	▲ +0.31%	10/20/2016
HANG SENG	HSI	23397.32	+92.35	▲ +0.4%	10/20/2016
NIKKEI 225	NKY	17235.5	+236.59	▲ +1.39%	10/20/2016